

АГУУЛГА

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ 3-4

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

НЭГ. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

1.1 Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	5-7
1.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	7-8
1.3 Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	8

ХОЁР. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ

2.1 Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	8-11
2.2 Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт	11-12
2.3 Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	12-13
2.4 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	13
2.4.1 Нийгмийн бодлогын хүрээнд	13
2.4.1.1 Боловсрол	13-15
2.4.1.2 Соёл, урлаг	15-16
2.4.1.3 Эрүүл мэнд	16-18
2.4.1.4 Биеийн тамир	18
2.4.1.5 Нийгмийн халамж хамгаалал	18-21
2.4.2 Төсөв санхүүгийн бодлого	21-23
2.4.3 Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих бодлого	23-24
2.4.4 Дэд бүтцийг хөгжүүлэх бодлого	24
2.4.4.1 Авто зам, тээврийн салбарт	24
2.4.4.2 Мэдээлэл, харилцаа холбооны технологи	24-25
2.4.4.3 Барилга, хот байгуулалт	25-27
2.4.4.4 Эрчим хүч	27
2.4.5 Газар тариалан, мал аж ахуйг хөгжүүлэх бодлого	27-29
2.4.6 Байгаль орчныг хамгаалах бодлого	29-30
2.4.7 Төрийн захиргааны удирдлагыг боловсронгуй болгох бодлого	30
2.4.7.1 Хүний нөөц	30
2.4.7.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээ	31
2.4.7.3 Мэдээлэл сурталчилгаа	31
2.4.7.4 Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	32
2.4.7.5 Гадаад харилцаа	32
2.4.7.6 Мэргэжлийн хяналт шалгалт	33
2.4.8 Хууль зүйн салбарын бодлого	33-37
2.4.9 Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, түүний хор хөнөөлийг арилгах талаар	37-38
2.4.10 Батлан хамгаалахын хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх талаарх бодлого	38-39

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭ

3.1. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг	
---	--

даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	39-40
3.2. Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	40-41

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

4.1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	41-42
4.2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	42
4.3. Төсөв, санхүүгийн ил тод байдал	42-43
4.4. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	43

ТАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

5.1. Булган аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	44-46
5.2. Хэрэглэгчийн үнэлгээ	46

ЗУРГАА. БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН 47

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын болон Булган аймгийн эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газар, аймгийн ИТХ-ын хуралдаанаас 2010 оныг “Бизнесийн хөгжлийн шинэтгэлийн жил”, “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгохоор дэвшүүлсэн зорилт, үндэсний хөтөлбөр үүдийг хэрэгжүүлэхэд аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагааг чиглүүлж ажиллалаа.

Булган аймаг нь 2010 онд:

- Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 70,0 хувьтай хэрэгжүүлж байна.
- Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2010 оны байдлаар 71,3 хувийн биелэлтэй хэрэгжиж байна.
- Булган аймаг 2010 онд өмнөх оноосоо дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг 12,2 хувиар өсгөсөн нь Мянганы хөгжлийн зорилтод сууриалсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод дэвшүүлсэн эдийн засгийн жилийн дундаж өсөлтийг ханган биелүүлсэн **4 дэх аймаг** болсон байна.
- Хүний хөгжлийн индексийн үзүүлэлтээр **улсад 5 дугаар байрт** орж байна.
- “Өрхийн хөгжлийг дэмжих аймгийн хөтөлбөр”-ийг 2 дахь жилдээ хэрэгжүүлж, сонгож авсан өрх бүрийг өрхийн хөгжлийн төлөвлөгөөтэй ажиллуулж, 2009 онд 303, 2010 онд 347 өрхийн амьжиргааг дээшлүүлснээр амьжиргааны батлагаажих түвшингээс доогуур орлогтой өрхийн нийт өрхөд эзлэх хувь 2008 онд 23,7 хувь байсан бол 2010 онд 4,5 хувиар буурч 19,2 хувь боллоо.
- 2010 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарлаж, “Эхийн эндэгдлийг бууруулах аймгийн стратеги төлөвлөгөө”-г хэрэгжүүлж, эхийн эндэгдэлгүй ажиллаа.
- Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, халдварт өвчний гаралт /10000 хүн амд/ 2009 онд 174,6 байсан бол 2010 онд 132,6 болгож буурууллаа.
- СӨБ-ын хамран сургалт улсын дундажаас 10,0 хувь, цэцэрлэгийн хамран сургалт улсын дундажаас 5,0 хувь дээгүүр байна.
- Улсын хэмжээнд анх удаа Дашинчилэн сумын сургууль үдийн хоолны **“Загвар цайны газар”**-тай боллоо.
- Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн хэмжээ тогтвортой өсч, эрчимжсэн аж ахуй нэмэгдэж байна.
- Мал аж ахуйн үйлдвэрлэл 2010 онд 10.2 хувь өсч, 2,3 сая толгой мал тоологдож малын тоогоор **улсын хэмжээнд эхний 5 орлоо**.
- Нийт малын тоонд **өндөр ашиг шимтэй малын эзлэх хувь 6,2-т** хүрч Орхон, Могод, Хишиг-Өндөр, Бүрэгхангай сумдад өндөр ашиг, шимтэй хонины шилмэл суурь, “Сэлэнгэ”, “Хартарлан” үүлдэрийн үхрийн аж ахуй байгуулагдлаа.

- “Атрын III аян”-ыг амжилттай зохион байгуулав.
- Усалгаатай тариалангийн хэмжээ нэмэгдэж 1896,4 га-д хүргэлээ.
- Нэгжийн ургац 12,6 цн хүрч, газар тариалангийн үйлдвэрлэлээр улсад 3-р байранд орлоо.
- Аймгийн хэмжээнд гурилын хэрэгцээг 2,5 дахин их, төмсний хэрэгцээг 100 хувь, хүнсний ногооны хэрэгцээг 70,0 хувь хангаж, Хангайн бүсийн зарим аймгуудад дотоодын хэрэгцээнээс давсан бүтээгдэхүүнийг нийлүүлж байна.
- Сүү, мах, гурил, шахмал түлшний үйлдвэр, төмрийн уурхайнууд шинээр бий боллоо.
- Хишиг-Өндөр, Рашаант, Сайхан, Баян-Агт, Могод сумдад 20-40 тн багтаамжтай хүнсний хөргүүртэй зоорь, мал нядалгааны цэг барилаа.
- Сайхан сумын Эрээний нүүрсний уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг **улсад жишиг** нөхөн сэргээлт болгож, улсын үзүүлэх сургалтыг аймагтаа зохион байгууллаа.
- Бүх сум, зарим баг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдож, нийт малчин өрхийн 76,0 хувь нь сэргээгдэх эрчим хүчинд холбогдолоо.
- Хөдөлгөөнт холбоо бүх суманд бий болж, 8 сумыг шилэн кабельд холболоо.
- Хатуу хучилттай засмал зам 9 сумын нутаг дэвсгэрийг дайран өнгөрч байна.
- Төсвийн орлого сүүлийн 5 жилийн дунджаар **26,8 хувь өсч**, орон нутгийн төсвөө бие даан бүрдүүлдэг аймаг болов,
- Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор жил бүр тулгамдсан тодорхой асуудлуудаар зорилт дэвшүүлж, жилийн ажил болгон зарлаж түүнд төр олон нийтийн анхаарлыг төвлөрүүлэн олон хэлбэрийн ажил зохион байгуулснаар тодорхой үр дүнд хүрч байна.
- Төрийн байгууллагын нээлттэй байдлыг хангах чиглэлээр үр дүнтэй ажлыг зохион байгуулж байна.
 - *Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн мэдээлэл өгөх.*
 - *Нээлттэй хаалганы өдрийг төрөл бүрийн хэлбэрээр зохион байгуулах*
- Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байна.
- Сэлэнгэ сум **Улсын “ТЭРГҮҮНИЙ СУМ”**-аар шалгарлаа.
- Нийгмийн хэв журмыг хангахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор байгууллагуудын **сайн дурын эргүүл ажиллуулж хэвшилээ**.
- ГХУСАЗЗ, Цагдаагийн байгууллагын идэвхтэй ажлын үр дүнд гэмт хэргийн гаралт буурсан зэрэг нь бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд ихээхэн түлхэц болсон гол гол ажлууд байлаа.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

НЭГ. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

1,1 Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт

Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажилтай уялдуулан зохион байгуулж ажиллаа.

Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын эхний үе шатанд /2007-2015 онд/ дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж дараах үр дүнд хүрч байна.

- 2009 онд нийт 1185 ажлын байр, 2010 онд нийт 1404 ажлын байр бий болгож, ядуурлын түвшин 2009 онд 23.4 хувь, 2010 онд 19.2 хувь болж буурч, ажилгүйдлийн түвшин 2009 оны эцэст 11,8 хувьтай байсан бол 2010 онд 5,8 хувьд хүрч буурлаа.

- Хүний хөгжлийн индекс 2007 онд 0.711, 2008 онд 0.728, 2009 онд 0.740-д хүрлээ.

- 0-5 насны хүүхдийн эндэгдэл 2000 онд 28 тохиолдол гарч байсан ба 2010 онд 24 тохиолдол болж буурч, 2010 онд эхийн эндэгдэлгүй ажиллалаа.

- Шийдвэр гаргах түвшинд жендерийн тэгш байдлыг авч үзвэл аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 9 хувь, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн 20.0 хувь, сумын ИТХ-ын дарга нарын 6.2 хувь, сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 37.5 хувь, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн 40.3 хувь, сумын Засаг дарга нарын 25,0, аймгийн Засаг даргын тамгын газрын хэлтсийн даргын 33.0 хувь, агентлагийн дарга нарын 27.7 хувь нь эмэгтэйчүүд ажиллаж байна.

- 6 настай хүүхдийн сургуульд хамрагдалт 2009 онд 81,5 хувь, 2010 онд 84,8 хувь, бага ангиас дунд ангид шилжин суралцагчид 2009 онд 99,7 хувь байсан бол 2010 онд 100,7 хувь, СӨБ-д хамрагдалт 2.0 хувь, цэцэрлэгийн хамрагдалт 4.4 хувиар тус тус өслөө. Бага ангийн хүүхдийн хүйсийн харьцаа охид 47,7 хувь, хөвгүүд 52,3 хувьтай байна.

- 2010 онд ЕБС-ийн 12 жилийн 3, 8-р ангийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүх багшид сургалт зохион байгуулж, сургалтын олон хувилбарт төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна. ЕБС-ийн 11 жилийн 288 бүлэг, 12 жилийн 99 бүлэг хичээллэж байна.

- 2010 онд дотоодын нийт бүтээгдэхүүн өмнөх оноос 12,2 хувиар өссөн нь Үндэсний хөгжлийн цогц бодлогод дэвшүүлсэн эдийн засгийн жилийн дундаж өсөлтийг ханган биелүүлсэн 4 дэх аймаг болж байна.

- Боловсруулах салбарын үйлдвэрлэл 2009 онтой харьцуулахад 38,2 хувиар өссөн байна.

- 2010 онд дотоодын 12,0 мянга, гадаадын 8,0 мянга гаруй жуулчдыг хүлээн авлаа.

- Аймгийн хэмжээнд өрхийн болон бичил, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжиж 2,4 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэртэй болж, 208 аж ахуй нэгжид зээл олголоо.

- Аймаг дотоодын гурилын хэрэгцээг 2,5 дахин, төмсний хэрэгцээг 100 хувь, хүнсний ногооны хэрэгцээг 70 хувь хангаж, хангайн бүсийн зарим аймгуудад дотоодын хэрэгцээнээс давсан бүтээгдэхүүнийг нийлүүлж байна.

- Сэлэнгэ, Хангал, Хутаг-Өндөр, Тэшиг, Булган, Бугат сумдад Казакын цагаан толгойт, Алатау, Хар тарлан үүлдрийн ичээл үрээр зохиомол хээлтүүлэг хийдэг боллоо.
- 2010 онд үр тариа 36.4 мянган тн, төмс 8.2 мянган тн, хүнсний ногоо 3.2 мянган тн-ыг хураан авч, тариалангийн талбай 5,8 мянган га-аар нэмэгдлээ. Улаан буудайн жилийн дундаж үйлдвэрлэл “Атрын 3-р аян” эхэлсэн 2007 онтой харьцуулахад 1,6-2 дахин өслөө.
- 2010 онд 111 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орж, хатуу хучилттай авто зам аймгийн авто замын сүлжээнд 9 хувийг эзлэж байна. Хатуу хучилттай авто зам нь 9 сумын нутгийг дамжин өнгөрөхдөө сумын төв болон сумын төвөөс 20 км-ын зайд өнгөрч байна.
- Нийт сумын төв төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдож, малчин өрхийн 76,0 хувь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглаж байна.
- Монголын гэр бүлийн өдрийг угтаж Аймгийн Эмэгтэйчүүдийн холбоо, “Хос багана” гэр бүлийн клубтэй хамтран “Гэр бүлийн үнэ цэнэ” 45 хоногийн аяныг зохион байгуулж “1000 гэр бүлийн баяр”, “Хос багана” гэр бүлийн уран бүтээлийн тоглолт хийж, шилдэг гэр бүлүүдийг сурталчилан алдаршууллаа. Хүүхдийн эрх хамгааллын асуудлаар сургалт сурталчилгаа зохион байгуулах хүүхэд, иргэдийн санал бодлыг сонсох чиглэлээр сум төр төсвийн байгууллагын холбогдох ажилтнуудад 10 удаа нийт давхардсан тоогоор 500 шахам албан тушаалтануудад, 16 сумын нийт 2438 хүүхдэд хүүхдийн эрхийн асуудлаар сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.
- Бага боловсролын бохир жин 85.8 болж, 2009 оныхоос 8.6 хувь өслөө. Дунд, суурь боловсролынх 87.2 хувь байна.
- Булган сумын “Эрдмийн өргөө” цогболбор сургууль нь 2010 онд “Боловсролын шинэчлэлийг манлайлагч шилдэг сургууль”-аар шалгарлаа.
- 2010 онд ХАА-ын мэргэжлийн МСҮТ-ийг шинээр байгуулж, 120 сурагч 4 мэргэжлээр сургаж эхэлснээр аймгийн хэмжээнд Мэргэжилийн сургалт үйлдвэрлэлийн төв 2 ажиллаж байна.
- Булган сумын иргэдэд 3 өрхийн эмнэлэг эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байна. Иргэдийн хүсэлтээр “Жаргахуй” өрхийн эмнэлгийн салбарыг Зүүн түрүүний багт ажиллуулж байна. “Эмийн цэцэглэн” өрхийн эмнэлэг дээр Японы ОУ-ын сувилахуйн сангийн “Эх нялхасын төлөө иргэдийн оролцоотой эрүүл хот бүтээх” төслийг 2008-2010 онд хэрэгжүүлж, бүх өрхийн эмнэлэгт 2010-2012 онд хэрэгжүүлэхээр сунгалаа.
- Эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжийн хангалт Нэгдсэн эмнэлэгт 89 хувь, сумдын эмнэлгүүдэд 88 хувьтай байна.
- Аймгийн Нэгдсэн эмнэлэгт “Энэбиш сан”-гийн санхүүжилтээр 40 компьютер суурилуулан, дотоод сүлжээ, интернетэд холбож, цахим картад шилжин цахим эмнэлэг болох эхлэл тавилаа.
- Аймгийн нэгдсэн эмнэлэг, Орхон аймгийн бүсийн оношилгоо эмчилгээний төвтэй хамтарч ажилласнаар онош тодруулах, эмчилгээ, шинжилгээ хийлгэхээр төрөлжсөн эмнэлгүүдэд хүргүүлсэн үйлчлүүлэгчдийн тоо 11 хувиар буурлаа.
- Эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмж 75 хувьтай байна.
- “Цэвэр орчин-Бодит ажил” сарын аяныг зохион байгуулж, төв суурин газар, түүний ойр орчмын гуу жалга, голын голдрилын 17,3 мянган тн хог хаягдлыг цэвэрлэв.
- Төв суурин газрын хүн амын 70 гаруй хувь, хөдөөгийн хүн амын 60 орчим хувь нь ундны цэвэр усаар хангагдлаа.

• Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг жил бүр аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, мөрдөн ажиллаж хэвшүүлээ. 2010 онд үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар 13,2 га газрыг дуудлага худалдаагаар, 19,6 мянган га газрыг төсөл сонгон шалгаруулалтаар иргэн аж ахуй нэгж байгууллагын эзэмшилд олгож, нийт 17,3 мянган га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэдэд өмчлүүлээд байна..

Аймгийн хэмжээнд Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт өссөн дүнгээр 49,6 хувь, тухайн жилд хийж гүйцэтгэсэн ажил 89,1 хувийн биелэлтэй байна.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг зорилт тус бүрээр гаргаж хавсаргав.

1.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс аймгийн Засаг даргад даалгасан нийт 93 зорилтын 170 арга хэмжээг хэрэгжүүлж 70,0 хувийн биелэлттэй байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг зорилт тус бүрээр үзвэл:

Д/д	Зорилт	Нийт заалтын тоо	Хэрэгжилтийн явц							Хувь
			100	90	70	50	30	10	Хугацаа болоог	
1	Хүн ам, нийгмийн зохистой бодлогыг хэрэгжүүлснээр иргэдийн амьдралын чанарыг сайжруулах	57	3	2	41	10	-	-	1	70,0
2	Үйлдвэржүүлэх бодлого хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангах	62	4	5	22	26	4	-	1	70,0
3	Байгаль орчны тэнцвэрт харьцааг хангах	29	1	1	16	10	1	-	-	70,0
4	Эрх зүйт төрийг төлөвшүүлж, засаглалын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох	17	2	3	4	8	-	-	-	70,0
5	Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого	5	1	-	1	2	-	-	-	70,0
6	Нийт /дундаж/	170	11	11	84	56	5	-	2	70%

Хэрэгжилтийн явц байдалд дүгнэлт хийхэд

- Нийгмийн салбарт – 1 арга хэмжээ
- Үйлдвэрлэл үйлчилгээ, хөдөө аж ахуй, байгаль орчны салбарт – 1 арга хэмжээ нийт 2 арга хэмжээ **хугацаа болоогүй** буюу хүлээгдэж байна. Үүнд: Алслагдсан болон говийн бүсийн нэмэгдэл олгох оновчтой хэлбэрийг бий болгоно гэсэн зорилт /2011-2012/ 2011 оноос эхлэнэ. "Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил"-ийг 2012 онд зарлана.

Жич: Монгол Улсын Засгийн газраас батлан гаргасан 2009 оны 11 дүгээр тогтоолын дагуу Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2011 оны 1 сарын 6-ны өдрийн 04/13 албан тоотоор хүргүүлж ажилласан болно.

1.2 Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт

Монгол улсын Засгийн газраас батласан 68 үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт 88,05 хувийн биелэлттэй байна.

Хэрэгжилтийн явц байдлыг салбар бүрээр дүгнэвэл:

д/д/	Салбар	Хэрэгжиж байгаа хөтөлбөр	Хэрэгжилтийн хувь	
			Тухайн жилийн хувь	Хэрэгжсэнээс хойшхи хувь
1	Нийгмийн салбарт	26	88,0	81,8
	- Эрүүл мэнд	9	82,2	81,7
	- Боловсрол	5	92,0	88,9
	- Соёл	3	90,0	74,7
	- Нийгмийн бүлгүүд	9	87,8	81,9
2	Хөгжлийн салбарт	31	92,25	61,8
	- Хөдөө аж ахуй	9	95,0	67,8
	- Үйлдвэрлэл үйлчилгээ	7	97,1	66,8
	- Дэд бүтэц	5	98,0	63,7
	- Байгаль орчин	10	78,9	48,9
3	Төрийн удирдлагын салбарт	2	80,0	60,0
4	Хууль эрх зүйн салбарт	8	80,0	77,5
5	Батлан хамгаалах салбарт	1	100	90,0
	НИЙТ	68	88,05	74,22

Засгийн газраас батласан эдгээр хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж 2010 онд нийт 9 дэд хөтөлбөр, бодлогыг аймгийн ИТХ, Засаг даргаас батлан гаргаж ажиллалаа.

Аймагт хэрэгжиж байгаа хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газраас батласан журмын дагуу хавсаргаж хүргүүллээ.

ХОЁР. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ

2.1 Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт


Үндсэн чиглэл 97.2 хувьтай биелэв.

Урьдчилсан байдлаар 2010 онд ДНБ хэмжээ 152.6 тэрбум төгрөгт хүрч 2009 оноос 12.2 хувиар, 1 үнд ногдох ДНБ 2609.8 мян. төгрөгт хүрч өмнөх оноос 17.8 хувиар өсөх тооцоотой байна.

Нэг хүнд ногдох ДНБ 2005 онд 505.5 мян. төг байсан бол 2010 онд 2609.8 мян. төг болсон нь 2005 онтой харицуулахад 2104.3 мян төгрөгөөр буюу 4.2 дахин өсөв.

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Нэг хүнд ногдох Дотоодын нийт



Монгол улсын Эдийн засаг нийгмийг 2010 онд гүйцэтгэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан 19 зорилт 61 арга хэмжээний хэрэгжилтийн байдал

№	Агуулга	Нийт заалтын тоо	Хэрэгжилтийн явч						Хувь	
			Тасарсан	Биелэлтийн байдал						
				100	90	70	50	30		10
1	Зорилт 1. Санхүү, эдийн засгийн хүндрэл, бэрхшээлийг даван туулахын тулд эдийн засгийн өсөлтийг дэмжих, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, томоохон хөрөнгө оруулалтын төслүүдийг цогцолбороор нь эхлүүлэх:	2	-	1	1	-	-	-	-	95
2	Зорилт 6. Эрчимжсэн өдөө аж ахуйг хөгжүүлж, үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагаанд тавих эрүүл ахуйн шаардлагыг өндөржүүлж, хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл, аюулгүй байдлыг дээшлүүлнэ:	17	-	11	5	1	-	-	-	95,2
3	Зорилт 8. Үн амын ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн дэд бүтцийн салбарыг хөгжүүлнэ:	3	-	3	-	-	-	-	-	100
4	Зорилт 10. Үржлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлнэ:	2	-	2	-	-	-	-	-	100
5	Зорилт 11. Байгалийн нөөцийн тогтвортой менежментийн үндсийг бэхжүүлж, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний чанар, үр дүнг сайжруулна:	4	-	3	1	-	-	-	-	97,5
6	Зорилт 12. Байгаль орчинд халд, тогтвортой аялал жуулчлалыг өсгүүлэх нөхцөлийг сайжруулна:	2	-	-	2	-	-	-	-	90
7	Зорилт 13. Үс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжиж, орон нутгийн түүхий эд, боломж, өөцөд тулгуурласан үйлдвэрлэлийг дэмжинэ:	3	-	3	-	-	-	-	-	100

8	Зорилт 15. Хөдөө орон нутгийн хүн амын интернет хэрэглээг нэмэгдүүлж, төрөөс иргэдэд хүргэх мэдээллийг цаг алдалгүй, түргэн шуурхай хүрэх боломжийг бүрдүүлнэ:	3	-	2	-	1	-	-	-	90
9	Зорилт 16. Нийгмийн халамжийн үйлчилгээнд шинэчлэл хийж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот үйлэгт оновчтой үргэх эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна:	1	-	1	-	-	-	-	-	100
10	Зорилт 17. Нийгмийн даатгалын өнөөгийн тогтолцоог шинэчлэн бэхжүүлнэ:	1	-	1	-	-	-	-	-	100
11	Зорилт 18. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлж, ядуурлын түвшинг бууруулна:	3	-	2	1	-	-	-	-	96,6
12	Зорилт 19. Үр мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлж, ердийн болон халдварт өвчнийг бууруулж, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, хүн амын өсөлтийг дэмжихэд чиглүүлнэ:	3	-	2	1	-	-	-	-	96,6
13	Зорилт 20. Боловсролын салбарын шинэчлэлийг үнзгийрүүлж, бүх шатны сургуулийн сургалтын үртээмж, чанар, тэгш байдалд бодитой ахиц гаргана:	6	-	5	1	-	-	-	-	98,3
14	Зорилт 22. Соёл, урлагийг хөгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг ахиулж, үгий хөгжлийн хэрэгцээнд чиглүүлнэ:	2	-	2	-	-	-	-	-	100
15	Зорилт 28. Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг шинэчилж, хяналт шалгалтын арга хэлбэрийг боловсронгуй болгож, мэргэжлийн хяналтын байгууллагын материаллаг баазыг сайжруулж, боловсронгуй чадавхыг дээшлүүлнэ:	1	-	-	1	-	-	-	-	90
16	Зорилт 30. Олон улсын зэргэлдээ орнуудын гамшгаас хамгаалах бүхий байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх, аврах ажлын техник, тоног төхөөрөмжөөр хангах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлж, гамшгаас хамгаалах чадавхийг нэмэгдүүлнэ:	2	-	2	-	-	-	-	-	100
17	Зорилт 33. Өрийн үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг сайжруулна:	1	-	1	-	-	-	-	-	100
18	Зорилт 34. Хууль тогтоомжийн өсөлт боловсруулахад шинжлэх ухааны үндэслэлтэй, боловсруулалтын шаардлагыг сайтар хангасан байх зарчмыг баримтлан эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлнэ:	1	-	1	-	-	-	-	-	100
19	Зорилт 35. Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, шаардлагатай	4	-	3	1	-	-	-	-	97,5

тоног өхөөрөмж, техник хэрэгслээр хангана :										
НИЙТ	61	-	45	14	2	-	-	-	-	97.2

2.2 Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт

Монгол Улсын хууль, Ерийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, хуралдааны тэмдэглэл зэрэг 252 шийдвэрийн 371 заалтыг хяналтанд авч хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.


№	Салбар	Хэрэгжиж байгаа шийдвэр	Хэрэгжилтийн хувь
1	Нийгмийн салбарт	110	91
2	Хөгжлийн бодлогын салбарт	64	92
3	Санхүү эдийн засгийн салбарт	25	96
4	Хууль эрх зүйн салбарт	22	98
5	Төрийн удирдлагын салбарт	29	98
	НИЙТ	252	95,0

Нийт дүнгээр танилцуулвал 371 заалтын 195 заалтыг 100 хувь, 176 заалт хэрэгжих шатандаа явж байна.

Хэрэгжилтийн явц		Бүгд	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		252	203	1	48
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо		371	296	1	74
Үүнээс	Биелсэн 100 %	195	154	1	40
	Хэрэгжих шатандаа	176	142	0	34
	90.0%	135	110	0	25
	70.0%	31	24	0	7
	50.0%	5	3	0	2
	30.0%	4	4	0	0
Тасарсан		0	0	0	0
Биелэлтийн дүн /хувь/		95	92,3	100	92,4

2010 онд аймгийн Иргэдийн Флөөлөгчидийн хурлаас батлан гаргаж аймгийн Засаг дарга, үүний Тамгын газарт даалгасан нийт 36 тогтоолын хэрэгжилтийг тооцож ажиллаа.

Аймгийн ИТХ-ын тэрүүлэгч дээс аймгийн Засаг дарга, үүний тамгын газарт даалгасан тогтоолуудыг бүтцээр нь авч үзвэл



Шийдвэрийн хэрэгжилтийг салбараар нь авч үзвэл

- Санхүү эдийн засгийн салбарт – 21 шийдвэр
- Нийгмийн хөгжлийн салбарт -1
- Хөгжлийн бодлогын салбарт – 14 шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажилласны дүнд 89,2 хувийн биелэлттэй байна.

Мөн аймгийн Засаг даргын 469 захирамжийн хэрэгжилтийг төр төсвийн байгууллагуудад хэрэгжүүлж хяналт-шинжилгээ, үнэлгээ хий хэд 95,3 хувийн биелэлттэй байна.

Жич: Монгол Улсын Засгийн газраас батлан гаргасан 2009 оны 11үдээр тогтоолын дагуу Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг 2011 оны 1 сраын 6-ны өдрийн 04/13 албан тоотоор хүргүүлж ажилласан болно.

2.3 Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт

Монгол Улсын Ерөнхий сайдтай аймгийн Засаг дарга нийт 10 заалттай үүргийг биелүүлэхээр батламжилсан бөгөөд 2010 онд 97,7 хувиар биелүүлж ажиллаа.

Аймгийн Засаг дарга “БАТЛАМЖ” бичигт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхээр хуулийн хүрээнд дараахи чиглэлд анхаарч ажиллаа.

- Монгол улсын хуулиудын хэрэгжилтийг зохион байгуулж байна. Захиргааны хариуцлагын тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор бүх сумдад Олон нийтийн байцаагч нарыг ажиллуулж, ажлын дэвтэр, торгууль шийтгэвэрийн хуудсаар хангалаа. Төрийн албан хаагчдад Монгол улсын Үндсэн хууль, бусад хуулийг сахин биелүүлж, үйл ажиллагаагаа хуулийн дагуу явуулж байхыг улирал бүрийн шуурхай зөвлөгөөн дээр анхааруулан үүрэг чиглэл өгч байна. Аймгийн Засаг даргаас 470 гаруй захирамж гаргаж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллаа

- Авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөг байгууллага бүр шалгуур үзүүлэлтээр тооцон мэдээ, мэдээллийн самбарт байршуулж, төсөв санхүүгийн нээлттэй байдлыг ханган ажиллаж байна.

- Эхийн эндэгдэлгүй ажиллаж, нялхас, 5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийг бууруулах цогц арга хэмжээг авч, халдварвчнийг бууруулан, СӨБ, бага, суурь боловсролын хамран сургалтыг өмнөх оноос ахиулж, ХАА-н мэргэжилтэй ажилтан бэлтгэх МСҮТ-ийг шинээр байгуулж, Булган хотын соёлын төвийг ашиглалтанд авч, 2009, 2010 онд 1587 байнгын ажлын байр бий болгож, 677 өрхийн амьжиргааг дээшлүүллээ.

- Нийгмийн дэг журам хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн эргүүл жижүүрүүдийг тогтмолжуулж, энэ чиглэлээр батлагдсан аймгийн Засаг даргын шийдвэрийг ХЗДХЯ-нд хянуулж, улсын бүртгэлд бүртгүүлээ. Аймгийн Засаг даргын 107 дугаар захирамжаар “Архины эсрэг хамтдаа” 2 сарын аян зарлаж, “Монгол хүнийг хайрлая” цуврал лекцийг “Сайхан Монгол урсгал” ТББ, Тамхи архины шалтгаант эмгэг судлалын төвтэй хамтран төв хөдөөгийн сумдад зохион байгуулж, “Асуудлаа хамтран шийдье” зөвлөгөөнийг хийлээ.

- Төсвөө бие даан бүрдүүлдэг аймгийн хувьд өсвийн зарцуулалтанд хатуу хяналт тавьж хариуцлага алдсан албан хаагчидад тухай бүр арга хэмжээ авч хөрөнгө оруулалт, тендерийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулж хэвшлээ.

- 2010 онд сахилгын шийтгэл оногдуулсан төрийн албан хаагчийн судалгаа гарган сумдуудаас аван нэгтгэл хийж судалгаатай болсон бөгөөд сахилга хариуцлагыг өндөржүүлэх төрийн албан хаагчдын сахилга хариуцлагын жилийн ажлыг үргэлжлүүлэх хэвшмэл болгох үүднээс сумдад ажиллаж байгаа групп шалгалтуудад хариуцлагын талаар үзэх, шалгах, зөвлөх асуудлыг тусгаж ажиллан төрийн албан хаагчдыг ажлын байранд нь мэргэшүүлэх асуудалд түлхүү анхаарлаа.

2.4 Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

Аймгийн Засаг дарга 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа.


Аймгийн Засаг даргын хөтөлбөр 81,3 хувьтай хэрэгжиж байна. Аймгийн ИТХ-ын 8-р хуралдаанаар өхөлбөрийн биелэлтийн явцыг хэлэлцээд “Хангалттай” хэрэгжиж байна гэж үнэллээ.

2.4.1 Нийгмийн бодлогын хүрээнд

2.4.1.1 Боловсрол


Боловсролын салбарыг 2007-2012 онд өмжүүлэх аймгийн бодлогыг хэрэгжүүлж байна.

Сургуулийн өмнөх насны 4202 хүүхдийн 3574 нь сургалтанд хамрагдснаар СӨБ-ын хамран сургалт 85,0 хувьд, цэцэрлэгийн байнгын бүлэгт 2294 хүүхэд хамрагдснаар цэцэрлэгийн хамран сургалт 54.5 хувьд хүрлээ.




Цэцэрлэгийн 88 бүлгийн 30.6 хувь буюу 27 бүлгийг тоглоомоор иж бүрэн хангаж, 16 суманд 24 гэр цэцэрлэг 54 багт ажиллаж, өдөөгийн 38 багт СӨБ -ын сургалтанд зориулагдсан богино долгионы радио станцтай боллоо.

ЕБС-ийн бага, суурь боловсролын хамран сургалтын цэвэр жинг насны ангиллаар авч үзэхэд 2010 онд 6-11 нас /бага боловсрол/-д **86.5**, 12-15 нас /суурь боловсрол/ -д **84.9** хувьтай байна.



Өөр аймаг, хотод сурч буй 6-15 насны Булган аймгийн харьяат сурагчдын судалгааг аймгийн хэмжээгээр гаргаж хамран сургалтыг тооцлоо.




Булган сумын 4-р цэцэрлэг Улсын тэргүүний цэцэрлэг, “Эрдмийн өргөө” цогцолбор сургууль “Боловсролын шинэчлэлийг манлайлагч”, өмт ус сургууль дугуйлан, сонгон, секц амжилттай зохион байгуулан улсад шалгарч БСШУЯ-аас 5.0 сая төгрөгөөр шагнуулж, Булган сумын 1 дүгээр бүрэн дунд сургууль “Шилдэг менежменттэй ТОП” сургуулиар шалгарлаа.

Японы ЖАЙКА-гийн “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төсөлд шалгарч **Хангайн бүсэд загвар байдлаар** хэрэгжүүлж эхэллээ.

БСШУЯ, ШУТИС-ийн “Шим тэжээл судлалынөв”, БНСУ -ын “Шим тэжээл” ТББ-ын хөрөнгө оруулалтаар Дашинчилэн сумын сургуулиудийн хоолны “Загвар цайны газар”-тай боллоо.

Мэргэжлийн багшийн хангалт, зэрэгтэй багшийнүүдийн с 2 жилд нэмэгдлээ.



“Хөгжсөн багшаас хөгжсөн хамт олон болох” аяныг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулж, бүх сургууль, цэцэрлэгүүд “Багшийн хөгжлийн төв” байгуулж, Баян-Агт сумын сургууль, “Эрдмийн өргөө” цогцолбор сургууль, Булган сумын 2, 4-р цэцэрлэг, Сэлэнгэ, Рашаант, Дашинчилэн сум, Хялганат тосгоны цэцэрлэгийн төвүүд аймгийн бүсийн “загвар төв”-үүд боллоо

Өргөн мэргэжлийн МСҮТ-ын дадлагын газрыг 52,0 сая төгрөгөөр засч, 70,0 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангаж, 100 ортой дотуур байрыг ашиглалтанд авч, Монголын МСС-ийн Техник Мэргэжлийн Боловсрол Сургалтын байгууллагуудын “Багшийн хөгжил үнэлгээ” тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж 37,2 мянган ам. долларийн төсөл хэрэгжүүлж байна.

Хичээлийн байрыг нийт 500,0 сая өгрөгөөр засварлан ХАА-н мэргэжлийн МСҮТ-ийг шинээр байгуулан 2010 онд 4 мэргэжлээр, 120 сурагчтайгаар хичээллэж, 400,0 сая төгрөгний төсөвт өртөгтэй оюутны дотуур байрыг ашиглалтад авч, 95,0 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмжөөр хангалаа.

Дотуур байранд суувал зохих малчдынүүдийн 95,7 хувийг байра нд оруулж, хатуу зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмжийн хангалтыг сайжрууллаа.



2.4.1.2 Соёл, урлаг

2010-2011 оны хичээлийн жилээс эхлэн аймгийн Үндэсний гэрээгээр 10 оюутныг СУИС-д суралцуулж байна.

Улс, аймаг, сумын хамгаалалттай 105 соёлын үл хөдлөх дурсгалт зүйлд Соёлын өвийн төвтэй хамтран тооллого хийж, шинээр 900 гаруй зүйлийг бүртгэж, газар зүйн байршил, насжилт, хамгаалалтын зэрэглэлийг тогтоолоо.

Хишиг-Өндөр сумын 11 жилийн сургуулийн морин хуурын “Молор-Эрдэнэ” чуулгын зардлыг төсвөөс гаргаж, улсын уралдаанд оролцууллаа.

Соёлын биет бус өв тээгч 91 хүнд онцгой өв тээгч “Батламж” олгууллаа.

Хуучин кино театрыг 1,0 тэрбум өргөгийн хөрөнгө оруулалтаар засварлан техник хэрэгслэлээр хангаж Булган сумын соёлын өв болгож ашиглалтанд авлаа. Тэшиг суманд шинээр соёлын өвийн барилгыг эхлүүлж, Баян -Агт сумын соёлын төвийн барилгын өргөнгийг 2011 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулж авлаа.

Орхон, Баяннуур, Могод, Бүрэгхангай сумын Соёлын төвийн сандлыг шинэчилэн, бүх Соёлын төвийг компьютер, принтерээр хангаж 13,0 сая төгрөг зарцуулж, Төв номын санг фургон машинтай болгож үүдлийн номын сангийн үйлчилгээг үзүүлж эхэллээ.

Соёлын салбарын хөрөнгө оруулалт өсч, үйлчлүүлэгчдийн тоо өмнөх оныхоос өслөө.



Төв номын санг интернетэд холбож, электрон каталогт шилжүүлэх ажлыг 90,0 хувьтай хийж, салбар номын санг Булган сумын “Хүний хөгжлийн төв” -д ажиллуулж байна.

Гурванбулаг, Хангал сум “Тогтвортой амьжиргаа-II” хөтөлбөрийн хөрөнгөөр 2.4 сая, БСШУЯ, Япон улсын төсвийн бус буцалтгүй тусламжаар 183 төрлийн 64,0 сая төгрөгний тус бүр 700 ширхэг номоор сум, сургуулийн бүх номын сангууд, Англи, Герман улсын Ротари клубээс хандивласан англи 1500 ширхэг номоор аймгийн өв номын сан фонд баяжилт хийгдлээ.

Булган суманд 11264 нэр өрлийн ном бүхий “Bookbrigde” англи номын санг шинээр байгууллаа.

2.4.1.2 Эрүүл мэнд

2010 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгож удирдамж, төлөвлөгөөний дагуу ажиллаж, аймаг 2, агентлагууд 11 болзолт уралдаан зарлан, сар бүр нэрэмжит ажлыг явуулж, дүгнэлээ.

Эрүүл мэндийн сайд, Засаг дарга хамтран “Эрүүл мэндийн салбарын хөгжлийн дунд хугацааны хөтөлбөрийг /2010-2015 он/-ийг батлан хэрэгжүүлж эхэллээ.

Эхийн эндэгдлийг бууруулах аймгийн стратегийг өвлөгөөг хэрэгжүүлж, жирэмсний эрт үеийн хяналтанд 1692 эх буюу 85,8 хувь хамрагдалаа.


Эхийн эндэгдэлгүй ажиллалаа.

0-5 насны хүүхдийн эндэгдлийн шалтгааныг судалж онол практикийн хурлыг хийж, зөвлөмж гарган нэгж байгууллагуудад хүргүүлэн хяналт тавьж ажиллалаа.

0-5 насны хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөнд 24,5 промилль байгаа нь улсын дундажаас 0,1 промилиэр бага байна.


Нийт халдварт өвчин 780 буюу 132,6 промилль байгаа нь өмнөх онтой харьцуулахад 284 тохиолдлоор, халдварт гепатитын 127 тохиолдол буюу 21,6 промилль байгаа нь өмнөх оныхоос 71 тохиолдол буюу 12,6 промилиэр тус тус буурлаа.

Нийт халдварт өвчин /10000 хүн амд /



Судалгаагаар дархлалын үвшин 98,0 хувь, тархалт 0,8 хувь байгаа нь вирусны гепатит В-ын өвчлөлийн тархалт багатай аймгийн тоонд орж байна.

Халдварт гепатит /10000 хүн амд /



Шувууны томуу, хүний томуугийн цар тахалтай тэмцэх, чадавхи сайжруулах төслийн баг аймгийн бэлэн байдалд үнэлгээ өгч, Шинэ томуугийн халдварын үед шуурхай тусламж үзүүлэх сургуулийг Булган, Рашаант, Гурванбулаг сумдад зохион байгууллаа.

ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар Орхон, Сайхан, Бугат, Хишиг-өндөр, Сэлэнгэ сум, Хялганат тосгонд 109,8 сая төгрөгийн түргэн тусламжийн автомашин, Эрүүл мэндийн газарт 60,8 сая төгрөгийн Toyota land Cruiser автомашины парк шинэчлэл, 16 сумын эмнэлэгт 4,0 сая төгрөгийн яаралтай тусламжийн иж бүрдэл, 4,8 сая төгрөгийн компьютер, сүлжээний тоног төхөөрөмж, Нэгдсэн эмнэлэгт 47 нэр төрлийн 220,7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, сумын эмнэлэгт 165 нэр төрлийн 2,9 тэрбум төгрөгийн багаж тоног төхөөрөмж, өрхийн эмнэлэгт 11 нэр төрлийн 1,0 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж олголоо.



2.4.1.4 Биеийн тамир

БТСГ-ыг фурган машинтай болгожүхбЕБС -ийн биеийн тамирын заалыг Үндэсний бөхийн дэвжээгээр ханган нийт 50,0 сая төгрөг зарцууллаа.

Секц дугуйланд хамрагдагсадын тоог нэмэгдүүлж, албан байгууллага аж ахуйн нэгжийн нийт 21942 хүний биологийн нас, биеийн жингийн индексийг гаргаж, бие бялдарын түвшин тогтоох үзлэгт 30500 хүнийг хамруулж үнэлгээ хийлээ.



Аймгийн хэмжээнд "Нийтийн биеийн тамир хөдөлгөөн -эрүүл мэндийг дэмжигч, сум байгууллага" шалгаруулах, сумдын эмнэлгүүдийн дунд "Тэргүүний ажиллагаатай биеийн тамир чийрэгжүүлэлтийн кабинет шалгаруулах" болзолт уралдаан зарлан дүгнэлээ.

Нийтийн биеийн тамирын 50 удаагийн уралдаан тэмцээн зохион байгуулж хамрагдсан хүний тоо 2009 оноос 12,5 хувиар өслөө.

“Хүн бүр өөртөө 30 минут хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж ажлын байранд хийх дасгал хөдөлгөөнийг албан байгууллага аж ахуйн нэгжүүдийн 40,0 хувь нь тогтмол цагт хийн хэвшиж байна.

Үндэсний спортын IV наадмын уралдаан тэмцээнийг зохион байгуулан 3,9 сая төгрөг төсвөөс зарцууллаа.

2.4.1.5 Нийгмийн халамж, хамгаалал

ХЭДС, ЖДҮХС -гийн өрөнгийг нэмэгдүүлж үр ашгийг дээшлүүлэн шинээр ажлын байр бий болгож ажил олгогчийг дэмжиж ажиллалаа. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн эх үүсвэрийн ашиглалт 98,3 хувьтай байна.

“Энэбиш” сангаас нийт 1261 иргэн аж ахуйн нэгжид 1,2 тэрбум өгрөгийн зээл олгож хөдөлмөр эрхлэлтийг дэмжлээ.

“Малчдын Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Хөтөлбөрт 30 малчин өрхийг хамруулж, 21,0 сая төгрөгний мал худалдан авч өглөө.

ХХҮХ-т бүртгэлтэй иргэнийг 6 сараас доошгүй хугацаагаар ажиллуулж байгаа 70 хүнийг ажлын байраар хангасан 24 ажил олгогчид гэрээний дагуу нийт 51.7 сая төгрөгний нөхөн олговор олгож урамшууллаа.

**Ажлын байр, өрхийн орлогыг дэмжсэн
санхүүгийн эх үүсвэр /сая төг/**

д/д	Хөрөнгийн эх үүсвэр	Хөрөнгө		
		2009 он	2010 он	
1	ЖДҮХСан	903,5	980,0	
2	Арилжааны банк	ХААН банк	0	650,0
		Хас банк	193,5	150,0
3	“Булган-Энэбиш” сан	560,0	560,0	
4	Улсын төсөв	565,0	580,0	
5	Орон нутгийн төсөв	130,0	130,0	
6	Бичил бизнес дэмжих сан	0	80,0	
7	ХЭДС	196,7	546,0	
8	Эмэгтэйчүүдийн бүлгийг дэмжих бичил бизнесийн зээл	0	103,8	
	НИЙТ	2548,7	3779,8	

2010 онд улирлын 787, байнгын 617, нийт 1404 ажлын байр бий болголоо.

Аймгийн ИТХ-аар баталсан “Өрхийн хөгжлийг дэмжих аймгийн хөтөлбөр” -ийг хэрэгжүүлж, 2009 онд 303 өрх, 2010 оны 374 өрх, нийт 677 өрхийн амьжиргааг дээшлүүлснээр, ядуурлын түвшин 2009 онд 23.4 хувь байсан бол 2010 онд 19.2 хувь болж буурлаа.

ХЯБХ-ийн хүрээнд 16 сумын нэн ядуу, ядуу эмэгтэйчүүдийн 26 бүлэгт 92,7 сая төгрөгийн бичил зээл олгож, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг дээшлүүлэх арга хэмжээ авлаа.

16 сум 1 тосгоны нэн ядуу, өрх толгойлсон 120 иргэнд гэр олголоо. Дэлхийн зөн ОУБ-ын “Булган нутгийн хөгжлийн хөтөлбөр”, “Булганхангай нутгийн хөгжлийн хөтөлбөр”-өөс 14 сумын орон гэрүй ядуу иргэдэд 28 гэр, 54 иргэнд хувийн байшин орон сууц барьж хүлээлгэн өглөө.

Нийгмийн эмзэг үлбрийн иргэдийн “Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр” -т хамрагдах 2673 иргэний судалгааг гарган мэдээллийн сан байгууллаа.

2010 оны 2-р сараас эхлэн “Хүний Хөгжил Сан” -гийн эх орны хишиг, хувийг иргэдэд олгох ажилд Халамж үйлчилгээний программ /“ХҮМ”/-ийг ашиглаж, өдөр бүр интернетээр мэдээ авч нэгтгэн аймаг улсад мэдээлж, нэрсийн жагсаалтыг банкинд тухайн өдөрт нь илгээж байна. Тус аймагт Эх орны хишиг хувь олголтын ажил 98,2 хувьтай явж байна.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бүтэн өнчин хүүхэд, өрх толгойлсон эх, нэн ядуу амьдралтай иргэдэд Хүний хөгжил сан, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох, хөнгөлөлт үйлчилгээ үзүүлэх арга хэмжээнд 2010 онд нийт 8,4 тэрбум төгрөгний татаас санхүүжилт авч, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээ үзүүллээ.

Кристина Нобелийн сангийн тэтгэлэгт хөтөлбөрт Булган, Орхон, Хишиг-Өндөр, Гурванбулаг, Дашинчилэн зэрэг сумдын эмзэг үлбрийн нийт 97 хүүхдийг хамруулсны



Нэрийн данс нээлгэх /хөдөлмөрийн дэвтэртэй, НД-ын дэвтэртэй, цэргийн батлахтай/ эрх бүхий 10176 иргэн нэрийн дансаа нээлгэж, хамрагдалт 95,0 хувьтай байна.

“Хүн байхын учир” аяны хүрээнд “Булган хангай нутаг минь-Бидний бахархал” нэг жилийн аян, “Булган хангайн хүүхдүүд” урлагийн их наадам, Хүүхдийн парламентыг зохион байгууллаа.

Хүүхдийн төлөө хэлтсийн барилгын их засварыг 45,0 сая өгрөгөөр хийж, техник хэрэгсэлд 5,0 сая, Үүхдийн “Жаргалант” зуслангийн засварт орон нутгийн төсвөөс 10,0 сая төгрөг зарцууллаа.

Булган суманд Хүүхэд залуучуудын паркийг 11 га талбайд байгуулахаар шийдвэрлэж, эхний ээлжинд 2 га талбайн 300 м хашааг орон нутгийн төсвийн хөрөнгөөр барин ногоон байгууламжийг эхлүүлэн ерөнхий төлөвлөгөөг хийлгэж байна.

2.4.2. Төсөв, санхүүгийн бодлого

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт санхүү эдийн засгийн талаар 7 үндсэн зорилт дэвшүүлж түүнийг хэрэгжүүлэх 17 арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна. Өрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудын заалт нэг бүрийг эзэнжүүлж жил улирлын төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

Орон нутгийн төсвийн 2011-2013 оны дунд хугацааны төсвийн төслийг аймгийн Хөгжлийн цогц бодлого, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр зэргийг үндэслэн Иргэдийн өлөөлөгчдийн хурал, Засаг дарга, түүний ажлын алба, Гүйцэтгэлийн аудит, Хот байгуулалт, тохижилт гэсэн өтөлбөр тус бүрээр төсвийн зарлагын эдийн засгийн ангилалаар боловсруулж 5,6 тэрбум төгрөгөөр батлуулсан нь өмнөх оноос 4,9 хувиар өссөн бөгөөд зарлагаас давсан орлого 872,0 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлэхээр аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлууллаа.

Аймгийн төсвийн зарлагын гүйцэтгэл /2008-2010 он/

Зардлын үндсэн ангилал	Гүйцэтгэл /сая төгрөгөөр/			Зардлын дүнд эзлэх хувь		
	2008	2009	2010	2008	2009	2010
Нийт зардал	4,619.3	3,821.4	4,904.5	100.0	100.0	100.0
Урсгал зардал	4,003.9	3,606.1	4,109.4	86.7	94.4	83.8
Бараа үйлчилгээний бусад зардал	1,813.5	1,431.5	1,684.4	39.3	37.5	34.3

Татаас урсгал шилжүүлэг	184.1	174.5	167.6	4.0	4.6	3.4
Хөрөнгийн зардал	615.4	215.3	805.1	13.3	5.6	16.4
Орон нутгийн хөрөнгө оруулалт	552.8	150.3	572.9	12.0	3.9	11.7
Орон нутгийн замын сан	62.6	65.0	222.2	1.4	1.7	4.5

Төсвийн төлөвлөлтөнд нэгдсэн мэдээллийн систем нэвтрүүлэх ажлын эхлэл болсон интернэтэд суурилсан программ нэвтрүүлж www.wage.mof.gov.mn хаягаар төсөвт байгууллагын бүтэц, орон тоо, ажиллагсдын дэлгэрэнгүй мэдээлэл, 2008, 2009 оны цалин, халаалт, цэвэр бохир ус, гэрэл цахилгааны зардлыг үндэслэлийг орууллаа.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2009 оны 162 тоот тогтоолыг хэрэгжүүлж, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй гадны 48 аж ахуйн нэгжийг орон нутгийн үндсэн болон салбар аж ахуйн нэгжид бүртгэснээс гадна 2010 онд 78 аж ахуйн нэгж байгууллага, 565 иргэнийг шинээр татварөлөгчөөр, 16 аж ахуйн нэгжийг шинээр НӨТ төлөгчөөр бүртгэж татварын бааз суурийг нэмэгдүүллээ. Татварын алба, татвар төлөгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор татварын хуулийн сургалт, сурталчилгааг татварөлөгчдийн ажлын байранд 32 удаа зохион байгуулж давхардсан тоогоор нийт 5875 татварөлөгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага хамрагдлаа.

Татвар төлөгчдийн дунд татварын тайланг цахим хэлбэрээр хүлээн авах сургалтыг зохион байгуулсан ба 3 дугаар улирлаас эхлэн 20 аж ахуйн нэгж байгууллагын аж ахуйн нэгж, нэмэгдсэнтөг, цалингийн ашгийн тайланг цахим хэлбэрээр хүлээн авлаа.

Татварын орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх талаар зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэний үр дүнд орон нутгийн төсвийн орлогод 5,2 тэрбум төгрөг орж орлогын төлөвлөгөө 105.7 хувиар биелж 2009 оноос 15,6 хувиар өссөн байна.


Орон нутгийн төсвийн орлогын 91.8 хувийг албан татварын, 5.7 хувийг татварын бус, 2.5 хувийг хөрөнгийн орлогоор бүрдүүлсэн байна.

Аймгийн төсвийн орлогын гүйцэтгэл /2008-2010 он/

Төсвийн орлогын үндсэн нэр төрөл	Гүйцэтгэл /сая төгрөгөөр/			Орлогын нийт дүнд эзлэх хувь		
	2008	2009	2010	2008	2009	2010
Албан татварын орлого	3,149.5	4,359.1	4,804.6	69.1	95.6	91.8
Татварын бус орлого	258.8	187.8	298.6	5.7	4.1	5.7
Хөрөнгийн орлого	6.8	15.2	128.7	0.1	0.3	2.5
Тусламжийн орлого	1,144.9	0.0	0.0	25.1	0.0	0.0
ОРЛОГЫН НИЙТ ДҮН	4,560.0	4,562.1	5,231.9	100.0	100.0	100.0

Аймгийн төсвөөс сумын төсөвт 1,7 тэр бум төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн олголоо.

2010 онд хийгдсэн хөрөнгө оруулалтыг эх үүсвэрээр авч үзвэл



2.4.3. Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих бодлого

Аймгийн хөгжлийн цогц бодлогын “Орон нутагт үйлдвэр, үйлчилгээ хөгжүүлэх чиглэлд” аж үйлдвэржүүлэлтийн бодлогоо тодорхойлж, бизнесийн өгжлийн шинэтгэлийн бодлого өтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх ар га хэмжээг зохион байгуулсанаар аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2009 оныхоос 9,6 хувиар өслөө.

Жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогын үр дүнд аймгийн хэмжээнд өрхийн болон бичил, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих 2448.6 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэртэй боллоо.

“Бизнесийн орчны шинэтгэлийн жил”-д хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан, ажлын хэсэг томилж сум болон холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллан төлөвлөсөн ажлаа 86,0 хувьтай биелүүллээ.

“Хөгжлийн шийдэл” ТББ, “Бизнес хөгжлийн төв”, мэргэжлийн холбоодтой хамтран бизнесөтөлөвлөгөө боловсруулах, бизнесийн орчин, хууль эрх зүйг сайжруулах зэрэг олон сэдвээр уулзалт, ярилцлага, сургалт, зохион байгууллаа.

Барилга, байгууламжууд барих ажлыг эхлүүлэх, хүлээн авахад холбоотой зөвшөөрлийг нэгтгэн нэг цонхны үйлчилгээнд шилжүүлж, техникийн нөхцөл авах байнгын комисстой болсноор зөвшөөрлийн гарын үсгийн тоо **50 хувь** хүртэл цөөрсөн байна.

Сүүлийн 3 жилд бизнес эрхлэлттэй холбоотой аймгийн Засаг даргын болон ИТХ-аас гаргасан захирамж, тогтоол шийдвэрүүдэд судалгаа хийж давхардсан утга санаа ижил заалтыг нэгтгэх, хуульд зааснаас бусад нэмэлт шаардлагуудыг үжингүй болголоо.

Аймгийн Засаг даргын шийдвэрээр Булган сумын тамгын газрын т үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх газрын харилцаа, банк санхүү, нийгмийн халамж, иргэдийн өргөдөл хүсэлт мэдээлэл зөвлөмжийн үйлчилгээнүүдийг төвлөрүүлсэн “Нэг цонх”-ны цэг нээн ажиллуулж байна.

Аймгийн хэмжээнд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний 500 гаруй аж ахуйн нэгж, цэг салбар, гахай, тахиа, мах үүний чиглэлийн эрчимжсэн фермерийн 20 -оод аж ахуй үйл ажиллагаа явуулж байна.

Эдийн засгийн ач холбогдолтой томоохон үйлдвэр бий болгох төсөл хөтөлбөрүүдийг хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжсэнээр Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Бүрэгхангай сумдад гурилийн үйлдвэрүүд шинээр байгуулагдаж, Орхон, Хутаг-Өндөр сумдын зарим гурилыг үйлдвэрүүд тоног төхөөрөмжөө шинэчилж, Бүрэгхангай, Тэшиг, Хутаг-Өндөр зэрэг сумдад тэжээлийн үйлдвэр ашиглалтанд орлоо.

“Гурил Тэжээл-Булган” ХК нь аймгийн өвд хоногт 120 тн буудай цайруулах хүчин чадал бүхий бүтээмж өндөртэй гурилийн үйлдвэрийн барилга угсралтыг гүйцэтгэж 2011 оны эхний хагас жилд ашиглалтанд оруулахаар ажиллаж байна.

Мөн тус компаний хуучин гурилийн болон тэжээлийн үйлдвэрүүд ажиллаж бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлж байна.

Аймаг дотоодын гурилын хэрэгцээгээ бүрэн хангаж гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ тогтворжиж бүсийн томоохон зах зээлүүдэд гурил нийлүүлж байна.

Хишиг-Өндөр суманд экспортод чиглэсэн бяслаг, үүний хуурай саамны, Булган суманд Чех улсын технологи бүхий сүү боловсруулах үйлдвэр, ХААИС -ын харьяа МСҮТ-ийн дэргэд сүүний цех суурилагдлаа.

Булган, Бугат, Хангал, Хутаг-Өндөр, Орхон, Сайхансумын мах, сүүний эрчимжсэн аж ахуйн үйл ажил лагааг дэмжиж 200.0 гаруй сая төгрөгний хөнгөлттэй зээл олгосоноор фермерийн аж ахуйн эхлэл тавигдлаа.


Хүн амын махны хангамжийг сайжруулах, хаврын улиралд хямд үнэтэй мах нийлүүлэх аж ахуйн үйл ажиллагааг дэмжиж орон нутгийн төсөвт 50,0 сая төгрөг тусгалаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвд 100,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий мал нядалгааны төвлөрсөн цэг, 100 тн-ны багтаамжтай өргүүртэй зоорь, Рашаант суманд малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах бага оврын үйлдвэр, Могод, Сайхан, Баян-Агт, Тэшиг, Хишиг-Өндөр сумдад мал нядалгааны цэг, 30-40 тн-ын хөргүүртэй зоорь барих зэрэг ажлууд хийгдэж байна.

“Булган-Мах маркет” мах боловсруулах үйлдвэр нь нэг ээлжиндээ 100 толгой бод буюу 400 толгой бог мал хөрөх технологийн шугамтай бөгөөд 5 00 тн мах махан бүтээгдэхүүнийг хадгалах хөргөлтийн системээ шинэчилсэн нь аймгийн хүн амын мах, сүүний хангамж нэмэгдэж, аймгийн өвд өвлийн улиралд нийлүүлэх сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдлээ.

Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлтээр аймгийн нийт хүн амын хүнсний хэрэглээг тооцоход өмсний хэрэглээг 100 хувь, гурилын хэрэгцээг 2 дахин их, хүнсний ногооны 65.0 хувь, махны хэрэгцээг 5 дахин их, сүүний хэрэгцээг 100.0 хувь дотоодын үйлдвэрлэлээр бэлтгэж байна.

Аймгийн боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өсөлтийн график: /тэрбум төгрөгөөр/



2010 онд боловсруулах аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл өмнөх оноос 38 хувиар өслөө.

Сүүлийн 2 жилд аймагт Хонгор толгойн гурлийн үйлдвэр, Хишиг-Өндөрийн сүүний үйлдвэр, Хялгант тосгоны шахмал үлшний үйлдвэр, Бүрэгхангайн төмрийн хүдэрийн үйлдвэр зэрэг томоохон үйлдвэрүүд ашиглалтанд орж байгаа нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг өсгөх талаар дэвшүүлсэн зорилт амжилттай хэрэгжих нөхцлийг бүрдүүлж 200 гаруй ажлын байрыг шинээр бий болгож ядуурлыг бууруулахад чухал алхам болж байна.

2.4.4. Дэд бүтцийг хөгжүүлэх бодлого

2.4.4.1 Авто зам, тээврийн салбарт

Аймгийн авто замын сүлжээнд хатуу хучилттай замын эзлэх хувийг нэмэгдүүлж, орон нутгийн авто замыг сайжруулах зорилт тавин ажиллаж, авто замын салбарт 6991,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдлээ. Үүнд:

1. Эрдэнэт-Булган-Уньт чиглэлийн 146 км хатуу хучилттай авто замын ажил бүрэн дуусч, ашиглалтанд орлоо.
2. “Мянганы зам” төслөөр Дашинчилэн-Өгийнуур чиглэлийн 109 км хатуу хучилттай авто зам барих ажил үргэлжлэн 79 км авто замыг ашиглалтанд хүлээн авлаа.
3. Булган хотын гэр хороололд 1 км хатуу хучилттай авто зам шинээр барьж, 2 км хатуу хучилттай авто замын дагуу гэрэлтүүлэг, гэрлэн дохио шинээр суурилуулж, ашиглалтанд орууллаа.
4. Орон нутгийн авто замын сангаас 222,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, Бугат, Баян-Агт, Булган, Баяннуур сумын зам засвар, шинэчлэлтийн ажлыг хийлээ.

Аймгийн авто замын сүлжээнд засмал замын эзлэх хувь 9 хувьд хүрч, 2008 оноос хойш засмал замын урт 1,6 дахин өссөнөөс гадна авто зам, замын байгууламжийн чанар дээшилж, “Булган АЗЗА” ТӨХК-ийн ажил үйлчилгээ өргөжиж, шинээр 24 ажлын байр нэмэгдэж, ажлын үйлдвэрлэлийн хэмжээ 150 хувиар өссөн байна.

Тээвэр, авто замын газар байгуулагдан, Булган-Орхон-Улаанбаатар чиглэлд хот хоорондын, орон нутгийн 2, хотын дотор 2 чиглэлд нийтийн тээврийн үйлчилгээний шинэ чиглэл нээж, 27034 иргэнд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн нь 2009 оноос зорчигч урсгалын хэмжээ 13,0 хувиар өслөө.

Авто вокзал, оношлогооны төвийн барилга барих ажлын зураг төсвийг мэрэгжлийн байгууллагаар хийлгэж, 2011 онд барихаар хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлээд байна.


Аймгийн ачаа тээвэрлэлтийг нэгдсэн зохион байгуулалтанд оруулсны үр дүнд Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас зарласан “Буудайн тээвэр-2010” тендерт шалгарч, 11.7 мянган тн ургацыг өөрийн аймгийн тээврээр гүйцэтгэлээ.

2.4.4.2 Мэдээлэл, харилцаа холбооны технологи

“Сумдын төвд интернетийн үйлчилгээ хүргэх” төслөөр Дашинчилэн, Хишиг-Өндөр, Булган, Хутаг-Өндөр, Гурванбулаг, Рашаант сумдад интернет төв байгуулагдаж, Сайхан, Хутаг-Өндөр, Хишиг-Өндөр, Рашаант, Гурванбулаг, Орхон сумын сургууль, Орхон сумын ЗДТГ, эмнэлэг интернетэд холбогдлоо.

Утасгүй холбооны системийг эрчимтэй хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэн Баян-Агт, Булган, Могод, Сайхан сум, Сайхан-Овоо багт “F” зоны үйлчилгээ үзүүлж, утасгүй телефоны тоо 923 болсон нь 2009 онтой харьцуулахад 37 хувиар өслөө.

Бүх суманд Мобиком, 8 суманд Скайтель, 10 суманд Юнитель, 9 суманд Жи мобайлийн салбарууд ажиллаж, үүрэн телефон хэрэглэгчийн тоо 33000 болсон нь 2009 онтой харьцуулахад 10,0 хувиар өсчээ.




2.4.4.3. Барилга, хот байгуулалт,

Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоог хөгжүүлж, хот, суурингийн оршин суугчдад таатай орчин бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэн орон нутгийн өсвийн хөрөнгөөр Булган хотын хөгжлийн ер өнхий төлөвлөгөөнд хэсэгчилсэн төлөвлөлт хийхүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллаж байна.

Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Залуу гэр бүлийн хотхон” байгуулах ерөнхий төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлээ.

Аймгийн хэмжээнд 2010 онд 13,5 тэрбум өгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэнээс 6,9 тэрбум буюу 51,1 хувь нь авто замын салбарт, 6,6 тэрбум буюу 48,9 хувь нь бусад салбарт хийгдсэн байна.

Хөрөнгө оруулалт /тэрбум төгрөгөөр/



Булган сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 100 хүүхдийн дотуур байр, Татварын хэлтсийн контор, Могод сумын 75 ортой цэцэрлэг, Хөдөө аж ахуйн мэргэжилтэн бэлтгэх сургалтын өвийн хичээлийн болон дотуур байр, Соёлын төв, анхдагчуудын музей, Хишиг-Өндөр сумын сум дундын 20 ортой хүн эмнэлэг зэрэг 7 барилга, байгууламж шинээр ашиглалтанд орлоо.

Баян-Агт, Дашинчилэн сумдын сургуулийн хичээлийн байр, Гурванбулаг сумын 240 суудалтай сургуулийн өргөтгөл, спорт заал, Сайхан сумын 100 ортой цэцэрлэг, Тэшиг сумын Соёлын төвийн барилга угсралтын ажил үргэлжилж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баян-Агт сумын сургууль, Могод сумын сургуулийн дотуур байр, Хишиг-Өндөр сумын цэцэрлэг, Хутаг-Өндөр, Гурванбулаг сумдын соёлын төв, Булган сумын Хүүхдийн төлөө хэлтэс зэрэг 15 барилгын засварын ажлыг хийлээ.

Хүн амын орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлэн шинээр 50 айлын орон сууц ашиглалтанд орж, 44 амины орон сууц шинээр баригдаж, нийтийн орон сууцны 2 барилгын дээврийг шинэчлэн засварлалаа.

Булган хотын төвлөрсөн усан хангамжийн нэгдсэн системийн барилга угсралтын ажил дуусч, ашиглалтанд орж, гэр хорооллын 1.1 км газарт цэвэр усан

хангамжийн шугам сүлжээ барих ажлын хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох дээд газруудад тавьж шийдвэрлүүлээ.

2.4.4.4. Эрчим хүч

Булган сумын Малчны хороо, Жаргалант хороо, Баяннуур, Хишиг-Өндөр сумын 0.4 квт-ын, Сэлэнгэ сумын 10 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын засвар үйлчилгээг хийж, цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжрууллаа.

Цахилгаан эрчим хүчний найдвартай ажиллагааг хангах, жижиг трансформаторын дэд станц барих зорилтыг хэрэгжүүлэн Тэшиг, Булган суманд 3 дэд станц, цахилгаан дамжуулах шугамын хамт барьж ашиглалтанд орууллаа.

Нийт сумын төв төвийн эрчим хүчний системд холбогдож, малчин өрхийн 76,0 хувь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглаж байна.


Булган хотыг найдвартай дулааны эх үүсвэрээр хангах зорилгоор дулааны станцыг хувийн хэвшлийн хөрөнгөөр барих ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, барилгын суурийн ажлыг эхлүүлээд байна.

2.4.5. Газар тариалан, мал аж ахуйг хөгжүүлэх бодлого

“Атрын-III” аяны үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хаврын тариалалтанд баримтлах агро өвлөмж, ургац хураалтын ажлыг богино хугацаанд хаягдалгүй хураах өвлөвлөгөө, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, “Малын хамуу өвчинтэй тэмцэх аймгийн хөтөлбөр, төлөвлөгөө”, “Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөө” зэрэг бодлогын баримт бичиг боловсруулан батлуулж хэрэгжүүллээ.

2010 онд тариалангийн атаршиж өнжөөсөн, ашиглалтгүй байсан 5820 мянган га талбайг эргэлтэнд оруулан нийт эргэлтийн талбайг 71063 га-д хүргэж, 91 аж ахуйн нэгж, 70 иргэнд эзэмшүүлж, нийт эргэлтийн талбайн 90 хувьд нь тариалалт хийж, тариалангийн талбайн бүртгэл тооллогыг талбай бүрээр гаргаж эзэмшүүллээ.

Үр тариа тариалсан талбай /га-аар, мянга/



Усалгаатай тариалангийн хэмжээ өмнөх оныхоос 100 орчим га-аар нэмэгдэж, үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний усалгаатай нийт талбайн хэмжээ 1896.4 га-д хүрэв.


Өндөр хүчин чадлын трактор, агрегат, үр тарианы комбайн, үтрэмийн машин, төмсний иж бүрдэл техник, тоног төхөөрөмжүүдийг авч техникийн паркийн 55 хувийг шинэчиллээ.

2010 онд нийт 31,1 мянган га талбайд үр тариа, 847 га талбайд төмс, 329 га талбайд хүнсний ногоо, 59 га талбайд арвай, 305 га талбайд овьёос, 9 га талбайд бог будаа, 14 га талбайд хөх тариа, 397 га талбайд ногоон тэжээл, 148.2 га талбайд жимс жимсгэний тариалалт хийж, үр тариа 36.4 мянган тн, төмс 8.2 мянган тн, хүнсний ногоо 3.2 мянган тн-ыг хураан авлаа. 2009-2010 онуудад жимс жимсгэний

тариалалтыг дэмжсэнээр тариалалтын хэмжээ 148 га-гаар нэмэгдэж, Булган суманд чацаргана боловсруулах цех байгуулагдаж, Сэлэнгэ суманд 50 га-д жимсний мод тарьж, услалтын систем суурилуулж боловсруулах цехийн эхлэлийг тавилаа

2010 онд аж ахуйн нэгжүүд Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас болон өөрсдийн хадгалсан үрээр тариалалт хийж, 32,9 мянган га талбайд уринш бэлтгэж нийт уриншийн 60 хувийг сайн, 40 хувийг чанарын онц үнэлгээтэй гүйцэтгэлээ.

Уриншийн хэмжээ /га-аар/



Малын үүлдэр угсааг сайжруулах таваарлаг байдлыг нэмэгдүүлэх, байгалийн эрсдлийг даван туулах нөхцөл бүрдүүлэх, малыг халдварт болон шимигчит өвчнөөс хамгаалах ажлыг зохион байгуулах чиглэлээр сумдын Засаг даргын Тамгын газрын бүтцэд мал эмнэлэг, үржлийн тасаг байгуулж, боловсон хүчин, ажлын байр техник тоног төхөөрөмжөөр хангалаа.

Мал аж ахуйн үйлдвэрлэл 2010 онд 10.2 хувь өсч, 2,3 сая толгой мал тоологдож малын тоогоор улсын хэмжээнд 5-д орлоо.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийн жинг тогтооход ямаанаас бусад төрөлд 0.01-0.9 пунктээр өсч, ямааны эзлэх хувийн жин 1.9 пунктээр буурсан нь бэлчээрийн даацийн хэтрэлт, бэлчээр талхагдалыг бууруулж, сүргийн зохистой бүтцэд эерэг нөлөө үзүүлээ.

Могод, Орхон, Бүрэгхангай сумдад нутгийн шилмэл омгийн хонины аж ахуй, Хишиг-Өндөр суманд үхрийн аж ахуй, ХХААЖДҮГ-ын дэргэд шилмэл хээлтүүлэгч өсгөн бойжуулах нутгийн өндөр ашиг шимтэй хонь, үхрийн аж ахуй байгуулагдлаа.

Малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, үржлийн ажлын чанар үр дүнг дээшлүүлж Казакын цагаан толгойт, Алатау, Хар тарлан үүлдрийн гүн хөлдөөсөн үрээр бод малд хээлүүлгийн ажлыг зохион байгуулж, бог малд Хангай, Дархад, Баяд, Эрчмийн хар, Баяндэлгэрийн улаанүүлдрийн хуц, ухныг хээлтүүлгийн ажилд сонгон ашиглаж байна.


Аймгийн хэмжээнд 38 мал эмнэлэг үржлийн нэгжтэй гурвалсан гэрээ байгуулан ажиллаж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь хийж 1.3 сая толгой малыг хамруулж 88,0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Паразиттах өвчний гаралт тархалт нэмэгдэж халдварлалт тогтвортой буурахгүй, малын чанар, тарга жчинд ихээхэн нөлөөлж байгаа учир малын “Хамуу өвчинтэй тэмцэх” хөтөлбөр боловсруулан ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд 2010 онд 2 суманд мал угаалгын ванн засварлаж, “Тогтвортой амжиргаа-2” төсөл, ХЯБХ-н санхүүжилтээр 2 ванн шинээр баригдаж, мал эмнэлэгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд улсын өсөв болон орон нутгийн хөрөнгөнөөс нийт 392,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдлээ.

Малыг эрсдлээс хамгаалах санг сумдад байгуулж, сум бүр 100-200 тн өвс, 150 тн тэжээл, Баян-Агт, Бүрэгхангай, Сэлэнгэ, Хутаг-Өндөр сумдын аж ахуйн нэгжүүд 1000 гаруй тн өвс, аймгийн нөөцийн салбарт 512 тн өвс нөөцөлж Засгийн газрын 166 дугаар тогтоолыг 92.1 хувь хангалаа.

Мянганы сорилын сангийн хот орчмын бэлчээрийг амжилттай хэрэгжүүлж улсын төсөв болон аж ахуйн нэгж иргэдийн өөрсдийн хөрөнгө оруулалтаар үхрийн болон хонины 12 эрчимжсэн аж ахуй байгуулагдаж үйл ажиллагаагаа эхлээд байна.

Эрчимжсэн мал аж ахуй /тоо/



“Бэлчээрийн менежментийн талаар баримтлах бодлого” боловсруулж, сумдад “Бэлчээрийн менежментийн хороо” төрийн бус байгууллага байгуулж бэлчээрийг зүй зохистой ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 8 сумын 1071 га талбайд бэлчээр хадлангийн талбайг хашиж, 6 сумын 14000 га талбайг малын хөлөөс чөлөөлөх арга хэмжээг зохион байгууллаа.

Улсын төсөв, төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр 44 шинэ худаг, малчид, иргэдийн хүчээр 19 гар худаг гарган, бэлчээрийн 80,0 гаруй мянган га талбайг усжуулж, 200 гаруй өрхийн 176000 орчим малыг усаар хангах боломж нөхцөлийг бүрдүүллээ.

Малын тоо толгой тогтворжин мал эдийн засгийн эргэлтэнд орж малчдын бодит орлого нэмэгдэж, ядуу малчин өрхийн тоо өмнөх оноос 5 гаруй хувь буурлаа.

2.4.6. Байгаль орчныг хамгаалах бодлого

Байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлж, ойн нөөц баялгыг хамгаалах зохистой ашиглах механизмыг бүрдүүлэх зорилгоор ойн менежментийн өлөвлөгөө гарган, 34 н өхөрлөлийн ойн зохион байгуулалтыг хийснээр ойг эзэнжүүлэн зохис той ашиглах, хамгаалалтыг сайжруулах боломжийг бүрдүүллээ.

Байгаль орчны доройтлыг бууруулах ажлын хүрээнд Булган хотын байгаль орчны нарийвчилсан судалгааг хийж, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 54 аж ахуйн нэгжийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хийлээ.

Сэлэнгэ, Орхон, Төв, Архангай аймгуудтай хиллэх сумдын хилийн цэс, аймгийн сумдын хилийн цэсийг тодотгож, координатжуулан, хувийн хэрэг, актыг бүрдүүллээ.

Цөлжилттэй тэмцэх ажлыг сум бүрт өрнүүлж, төлөвлөгөө гарган ажилласнаар аймгийн хэмжээгээр 7 өрлийн 160,2 мянган ширхэг тарьц, суулгац тарьж, 310 аж ахуй нэгж байгууллага, 5874 иргэн оролцож, 115,6 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оноос 6,9 дахин өссөн байна.

Тарьсан мод бутны тоо, зарцуулсан хөрөнгө

	2007	2008	2009	2010
Тарьсан мод бут /мян. ш/	20,3	8,6	20,6	160,2
Зарцуулсан хөрөнгө /сая төг./	14,7	6,2	14,9	115,6

Аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн үндэснээс өргөтгөж, Тэшиг, Хутаг - Өндөр, Сэлэнгэ сумдын нутаг дэвсгэрийг хамран орших Зэд, Бүтээл, Хантайн нуруу,

тэдгээрийн орчмын газар нутгийн ой, байгалийн ургамал болон биологийн өрөл зүйлийг хамгаалах зорилгоор орон нутгийн хамгаалалтанд авлаа.

Аймгийн тусгай хамгаалалттай газар нутгийн болон аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг жуулчны бааз, зочид буудлын мэдээллийн сантай болж, амралт сувиллын зориулалтаар 9 га, үйлчилгээний зориулалтаар 4,2 га газрын эзэмших эрхийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад дуудлага худалдаагаар олгож, нийт 49,9 сая төгрөг, төсөл сонгон шалгаруулалтаар 19,6 мянган га газрыг эзэмшилд олгож, 110,1 сая өгрөгийг тус тус төсөвт оруулсны дээр аймгийн хэмжээнд 8113 иргэнд 17,3 мянган га газрыг өмчлүүлээд байна.

Агаарын бохирдлыг бууруулах, үлшний модны хэрэгцээг багасгах зорилгоор Бугат суманд шахмалүлшний үйлдвэр шинээр байг уулж, аймгийн ЖҮДС -аас шахмал түлш үйлдвэрлэх 2 төсөлд дэмжлэг үзүүлэв.

“Цэвэр орчин-бодит ажил” сарын аяныг аймгийн хэмжээгээр зохион байгуулж, нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 15,8 мянган га газрын хогийг цэвэрлэж, 17,3 мянган тн хогийг ачиж зайлуулсан байна.

Өвөлжөө хаваржаа болон голын голдрилыг цэвэрлэж, 22,7 мянган малын сэг зэмийг устгаж, 161 тн хог хаягдлыг булшилж, устгалт хийх ажлыг зохион байгууллаа.

Улсын төсвийн хөрөнгөөр 5 га-д ойн хамгаалалтын туслах зурвас байгуулж, 76 хувийн амьдралттай байна.

2010 онд ойгоос бэлтгэсэнүт лшний модны хэмжээмнөх оноос 0,6 хувиар буурлаа.

Ойн хортон устгалтын ажлыг 20,5 мянган га-д, хортны тархалтын судалгааг 110,0 мянган га-д хийж гүйцэтгэлээ.

Улсын төсөв, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 2010 онд 27 б улаг шандны эхийг тохижуулан хамгаалснаар нийт булаг шандны 36 хувь хамгаалагдлаа. Ойн нөхөн сэргээлтийн ажлыг 650 га, уул уурхайн нөхөн сэргээлтийг 84,7 га-д хийж, Сайхан сумын Эрээний үүрсний уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг **улсад жишиг** нөхөн сэргээлт болгож, улсын үзүүлэх сургалтыг аймагтаа зохион байгууллаа.

Үйлвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан ус ашиглалтын гэрээний биелэлтийг тооцож ажилласнаар орон нутгийн төсөвт 1781,1 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 101 хувьтай биелүүллээ.

Мөн түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогчдоос төлбөр авдаг болж хэвшүүлэн 1314.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

2.4.7. Төрийн захиргааны удирдлагыг боловсронгуй болгох бодлого

2.4.7.1 Хүний нөөц

“Суралцагч байгууллагыг өгжүүлэх манлайлал” сэдэвт төслийн сургалтад Бүрэгхангай, Баяннуур, Рашаант зэрэг сумын төсвийн байгууллагын Ерөнхий менежер нарыг хамрууллаа.

Засгийн газрын захиалгын дагуу удирдах ажилтны манлайлах ур чадварыг дээшлүүлэх зорилтот болон богино хугацааны сургалтанд агентлагийн дарга, ЗДТГ-ын зарим хэлтсийн дарга, ажилтнуудыг оролцуулав.

Төрийн албан хаагчын бүрэлдэхүүн хөдөлгөөний 2009 оны тайланг үндэслэн аймгийн төрийн албаны хүний нөөцийн төлөвлөлтийг боловсруулж байна.

Төрийн албаны мэргэшлийн шалгалт өгч төрийн албан тушаалд анх орох нөөцөд бүртгэгдсэн 27 иргэн төрийн жинхэнэ албанд томилогдоод байна.

2.4.7.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Аймгийн Засаг даргын даргын баталсан удирдамжийн дагуу 6 сум 4 байгууллагад зөвлөн туслах ажлын хэсэг ажиллуулж, бодлогын зөвлөмжөөр хангав

Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмыг шинэчлэн мөрдөн ажиллаж байна.

Сумын Засаг дарга болон ЗДТГ-ын дарга, өрийн захиргааны асууудал хариуцсан мэргэжилтэн, багийн Засаг дарга нарт хяналт-шинжилгээ, үнэл гээний чиглэээр сургалт семинар өгч ажиллалаа. Аймгийн Засаг даргын шийдвэрээр агентлагуудад өөрсдийн үйл ажиллагаанд хяналт -шинжилгээ, үнэлгээ хийх мэргэжилтнийг бүт эцдээ бий болгож ажиллах үүрэг болголоо. Ингэснээр сум, агентлаг дээр хэрэгжиж байгаа хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын эвлөлийн хурлаар сонсгол хэлбэрээр оруулж цаашид авах арга хэмжээ, хөрөнгө санхүүгийн асуудлыг шийдэх нөхцлийг бүрдүүлж байна.

Аймгийн ЗДТГ-ын ХШҮТ-ийн үйл ажиллагаа жигдэ рч жилийн төлөвлөгөөтэйгээр ажиллаж сумдад газар дээр нь үндэний хөтөлбөрүүдээс сонгож үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг тогтмол хийж байна. Хөтөлбөрийн явц байдлын үнэлгээг сум, агентлагуудад шалгасан днг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж цаашид авах арга хэмжээг тодорхойлон ажиллаж байна.

2.4.7.3. Мэдээлэл сурталчилгаа

Сум агентлагууд “Бид танд ил тодчилж байна” самбар гарган тогтмол ажиллуулж, “Нээлттэй хаалга”-ны өдрүүдийг тусгай удирдамж өлөвлөгөөний дагуу амжилттай зохион байгуулж хэвшлээ.

Агентлагууд 2009 оньүйл ажиллагаагаа бүх, аймгийн төвийн байгууллага, иргэдэд сурталчилсны зэрэгцээ, 2010 оны үйл ажиллагаагаа сурталчлах хуваарь чиглэл гарган өгч удирдах ажилтны шуурхай цуглаанд мэдээлэх, орон нутгийн телевизийн шууд нэвтрүүлэгт оролцуулах ажлыг зохион байгуулж, хөдөө орон нутгаар явж үйл ажиллагаагаа мэдээлэх, иргэдийн санал бодлыг сонсохажил хийгдэж байна.

Улирал тутам мэдээллийн сэдвийн чиглэл гарган сумдад өгч, ярианы сэлвээр хангаж ажиллалаа.

Аймгийн сонинд сар тутам “Нутгийн захиргааны байгууллагын ажил, үйлчилгээ” үүр гаргаж, орон нутгийн телевизид “Тамгын газраас ярьж байна” нэвтрүүлгийг 7 хоног тутам явуулж, улирал тутам “Танд илгээх мэдээлэл” товхимол гаргаж үйл ажиллагаагаа иргэдэд мэдээлж байна.

Монцамэгийн мэдээ, Нийгмийн толь зэрэг өвийн хэвлэлүүдэд 2010 онд 50 шахам мэдээ, ярилцлага, нийтлүүлж, аймаг сум байгууллагаас зохион байгуулсан ажлыг нийтэд мэдээллээ.

Шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн “Guren.mn”, “Localnews” сайттай холбоо тогтоон 28-30 мэдээ ярилцлага байршуулснаар аймаг орон нутагт зохион байгуулсан ажлыг олон нийтэд шуурхай өргөн хүрээнд хүргэх боломж бүрдэж байна.

Булган аймгийн 2010-2021 онд хөгжүүлэх цогц бодлогыг олон нийтэд мэдээлж шуурхай хүргэхэд анхаарч хялбаршуулсан мэдээллийг бүх сум агенлагт хүргүүлсний дээр аймгийн сонинд цуврал нүүр 2-ыг нийтлүүлээд байна.

2.4.7.4. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД					
Бичгээр		Амаар		Нийт ирсэн өргөдөлийг шийдвэрлэсэн байдал	
				Хувь	Тоо
3164		2303		99,1	5420
ҮҮНЭЭС					
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ					
Бичгээр		Амаар		Нийт ирсэн өргөдөлийг шийдвэрлэсэн байдал	
Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо
70,6	166	29,4	69	97,4	229

Хугацаа хэтрүүлсэн өргөдөл байхгүй. Иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу 40 иргэнтэй биечлэн уулзаж, 20 хүний ар гэрээр нь очиж ахуй байдалтай нь танилцав. Зарим өргөдөлд хөндөгдсөн асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтнаас тодруулга, лавлагаа авсныүндсэн дээр дүгнэлт гаргах зэргээр ажилл алаа. Урьд онтой харьцуулахад бичгээр ирсэн өргөдөл 54 -өөр буюу 24.8 хувь багассан нь иргэдэд тодорхой мэдээлэлэгснөөр илүү шат дамжлагагүйгээр сум байгууллагадаа хандсан байна гэж дүгнэлээ.



Хууль ёс, дэг журмын асуудлаар 3, удирдлага зохион байгуулалтын чиглэлээр 5, сургууль дамжааны асуудлаар өргөдөл ирсэн нь хамгийн цөөн асуудал буюу нийт өргөдлийн 1,8-3,6 хувийг эзэлж байна.

Иргэдээс ирүүлсэн 44 төслийг дэмжин 649 сая төгрөгний зээл олгож, 150 хүнийг ажилд зуучлаж, 148 иргэнийг гэртэй, 54 иргэнийг орон байртай болгож өгөв.

2.4.7.5. Гадаад харилцаа

ОХУ-ын Буриад Улсын Закамень районтой уламжлалт хамтын ажиллагаагаа хөгжүүлж ажиллалаа.

Шууд харилцаа тогтоосон БНСУ-ын Дэгү хотын Дунү д үүрэгтэй хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах нотломж бичигт гарын үсэг зурлаа.

УИХ-ын гишүүн Э.Мөнх -Очирын санаачилгаар Монгол Улс–БНСУ-ын хамтын ажиллагааны форумыг аймагтаа амжилттай зохион байгуулж 2 талаас парламентийн гишүүд, бизнесийн төлөөлөгчид, холбогдох яам газруудын мэрэгжилтнүүд сум агентлагийн удирдлагууд оролцлоо.

Зүүн хойд Азийн бүс нутгийн Засаг захиргааны холбооноос зохион байгуулж буй арга хэмжээнүүдэд аймгийнхаа төлөөллийг оролцуулж байна.

“ХЯБХ”, “Тогтвортой амжиргаа-2”, “Дэлхийн зөн” зэрэг олон улсын томоохон 20 гаран төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна.

2.4.7.6. Мэргэжлийн хяналт шалгалт

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын лаборатори нь 2010 оны 6 сард 51 бүтээгдэхүүнд 319 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээ хийхээр 3 жилийн хугацаатай итгэмжлэгдлээ. Энэ нь мөнх итгэмжлэлээс 9 бүтээгдэхүүн, 63 үзүүлэлтээр өссөн байна. Аймгийн хэмжээнд анх удаа Eliza-ын тусламжтайгаар өндөг, сүүнд миламин тодорхойлох шинжилгээг хийдэг боллоо. Хүнсний бүтээгдэхүүнд будагч бодис тодорхойлох шинжилгээг нимгэн үет хромографи дээр туршин нэвтрүүлж байна. Хяналт шалгалтанд хамрагдаж байгаа газруудын удирдах ажилтан, ажил үүрэг хариуцан гүйцэтгэдэг хүмүүсээс үйл ажиллагааны чиглэлийн дагуу хууль тогтоомжийн мэдлэг шалгах тестээр шалгалт авдаг болсон нь хууль эрхийн мэдлэгийг дээшлүүлэх, хууль тогтоомж сурталчилахад чиглэсэн ажил болж байна. Сумдын байцаагч нарын ажлыг сайжруулахад анхаарч жилд 2-4 удаа сургалт семинар зохион байгуулж, хуулийн сургалт явуулах, эрхийн актүйлдэх дадлага хийлгэх, гарын авлага материалаар тасралгүй хангаж, түвшин тогтоох үзлэг хийж, урамшилд хамруулах, туршлага судлуулах ажлыг өргөн хүрээтэй зохион байгуулж хэвшиж байна.


Аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь 10 сум, 1 тосгоны 58 албан байгууллага, 29 аж ахуй нэгж, худалдааны 60, нийтийн хоолны 45 цэгт стандарт мөрдөлтийг шалгахад худалдааны цэгүүдийн стандартын биелэлтийн дундаж 82,1, хоолны газрууд 80,9 хувийн биелэлттэй хангалттай үнэлгээтэй байна.

2.4.8. Хууль зүйн салбарын бодлого

Олон нийтэд хууль зүйн мэдээ, мэдээлэл, анхан шатны туслалцаа авах боломж бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлж бүх шатны Засаг даргын Тамгын газруудад эрх зүйн бүртгэл лавламжийн сан бүрдүүлж, хууль тогтоомжид орсон өөрчлөлт хөдөлгөөнөөр баяжуулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллалаа. Аймгийн Нийтийн номын санд хуулийн булан нээж, хтөгөлдөр хуулиудын эмхтгэл, хууль зүйн ном гарын авлагаар мэдээллийн сан бүрдүүлсэн нь хууль унших боломжийг иргэдэд ойртуулсан ажил боллоо.

Эрх зүйн сургалт сурталчилгааны дунд хугацааны хөтөлбөрийг сурталчлах нэг сарын аян, авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хоёр сарын аяныг зарлаж, аяны хугацаанд шударга ёсны агуулга, үзэл санааг сурталчилсан нээлттэй хэлэлцүүлэг, гар зураг, эссэ бичлэгийн уралдаан зэрэг арга хэмжээг аймаг, сумдад зохион байгуулж дүгнэлээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэс т “Эрх зүйн туслалцааны төв” байгуулагдаж төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөлөл, хууль зүйн анхан шатны тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг болсон нь хууль зүйн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлээд байна.



Хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор байгаль орчныг хамгаалах, хүнсний аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журам хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг хийхдээ мэргэжлийн болон хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж байна.

Хүний эрхийг хамгаалах өдрөөр жил бүр мэдээлэл сурталчилгааны өдөрлөг, нэгдсэн хэлэлцүүлэг хийж хэвшсэн бөгөөд 2010 онд эмэгтэйчүүдийн холбоотой хамтран үний эрхийн талаархи үндсэн илтгэлүүдийг сурталчилсан нээлттэй хэлэлцүүлэгийг зохион байгууллаа.


Иргэний нийгмийн байгууллагын үйлдвэртэй хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж ажилласан. Үр иргэний түншлэлийг сайжруулах зорилгоор 3 удаа уулзалт хийж, өрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний жагсаалтыг гаргасан ба 2011 оноос хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Шударга ёс ил тод байдлыг хангах чиглэлээр өрийн бус байгууллагын оролцоог дэмжиж хамтран ажиллаж байна. Тухайлбал өөний хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын төлөөллийг тогтмол оруулж байгааг зэрэгцээ, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягын сургалтыг "Сайхан монгол урсгал" төрийн бус байгууллагатай хамтран зохион байгууллаа.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санд 2010 оны 7 сарын 1-н төвлөрүүлж, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд, олон нийтийн байцаагч, үүргээ амжилттай биелүүлсэн иргэд, албан хаагчдын урамшуулал, хууль хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих хөрөнгө оруулалтуудыг шийдвэрлэх зэрэгт зарцуулав.


Нийгмийн дэг журам хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр батлагдсан шийдвэрт хяналт үнэлгээ хийсэн дүнг үндэслэн "Хүүхдэд зориулсан ажил үйлчилгээний нийтлэг журам"-ыг шинэчлэн батлуулав. Мөн Хүүхдийн төлөө хэлтсийн дэргэд Хуульчдын зөвлөх байг байгуулан, хүүхдийн эрхийн зөрчилд өртсөн хүүхдийн эрхийг хамгаалах, нөхөн сэргээх, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг 10 гаруй хүүхдэд үзүүллээ.

Гэмт хэрэгт холбогдсон болон эрх нь зөрчигдсэн хүүхдийн тоо /2009-2010 он/



Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, уралдаан тэмцээнд иргэд, олон нийтийн дунд тогтмол зохион байгуулагдаж хэвшлээ. Замын хөдөлгөөнд оролцогчдын соёл, хяналтыг сайжруулах зорилгоор орон нутгийн төсвөөс хяналтын пост, гэрлэн дохио, эргүүлийн автомашин зэрэг барилга объект, хөрөнгийг шийдвэрлэв.

Аймгийн ИТХ-ын 2010 оны оны 38 дугаар тогтоолоор "Согтууруулах ундаагаар худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам"-ыг шинэчлэн батлуулж, тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй уулзалт хийж, орон нутгийн стандартыг хангах талаар зөвлөж биелэлтийг тооцон, шаардлага хангаагүй цэгүүдэд үүрэг өгч ажиллалаа.



- Тусгай зөвшөөрөл эзэмших эрхийг
- Цуцалсан – 8
 - Түр хугацаагаар түдгэлзүүлсэн – 46

Архины хор уршиг, архидалтаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг Тамхи архины шалтгаант эмгэг судлалын төвтэй хамтран хийж бүх сум, ЕБС-иудын ахлах ангийн сурагчдын дунд сургалт лекц зохион байгуулав. Мөн төвтэй гэрээ байгуулан сэтгэл заслын эмчилгээнд согтууруулах ундаа байнга хэрэглэдэг 7 хүнийг хамруулж, тэдний оролцоотой Эрүүл идэвхитэй амьдралын клуб байгуулав.


Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтарсан багийн оролцоо үйл ажиллагааг идэвхижүүлэх ажлыг “Дэлхийн өн” ОУБ-тай хамтран зохион байгуулав.

Нийгмийн дэг журам хангах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах Олон нийтийн байцаагчийг бүх сумдад ажиллуулж, 2 удаа сургалт хийж, арга зүйн зөвлөгөө өгөв.


Аймгийн хэмжээнд 243 гэмт хэргүүдтөгдсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 46 хэргээр буюу 16 хувиар буурсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт, үүрэгдийн удирдлага, хариуцлагыг сайжруулсанаар хяналт, харуул хамгаалалт муугаас шалтгаалан үйлдэгддэг төрлийн гэмт хэргүүд өмнөх оноос буурлаа.

Гэмт хэргийн гаралт 2009-2010 он /тоогоор/




10000 хүнд ногдох гэмт хэргийн тоог улс болон аймгийн дундажтай харьцуулахад



Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс эд хөрөнгийн, хуулийн этгээдийн, хүн амын бүртгэлийг нэг цэгт төвлөрүүлэн гүйцэтгэж, бүх төрлийн бүртгэлийн үйл ажиллагаа өмнөх оноос өссөн дүнтэй байна. Тухайлбал өмчлөх эрхийн бүртгэл өмнөх оноос 68,4 хувиар, эд хөрөнгийн эрхийн бүртгэл 77,4 хувиар, хуулийн этгээдийн бүртгэл 13,1 хувиар, иргэний анхан шатны бүртгэлүүдээс төрөлт, гэрлэлт хоёроос бусад нь 13,4 хувиас 3 дахин өслөө.

Шилжилт хөдөлгөөний байдлыг сүүлийн 5 жилийн байдал



Хүн амын бүртгэл мэдээллийн сан цахим хэлбэрт шилжиж, иргэний бичиг баримтын өрчил арилгах ажлыг 2008 -2009 онд хийж, 2010 онд амын шинэчилсэн бүртгэлд 41845 иргэн хамруулахаас 40074 иргэн хамруулж, 95,8 хувьтай гүйцэтгэв. Иргэний бүх төрлийн лавлагаа, мэдээллийг цахим сангаас авах боломж Улсын бүртгэлийн хэлтэс, Булган сумын Засаг даргын Тамгын газрын иргэний бүртгэлийн ажилтнуудад бүрдээд байна.

Аймгийн Цагдаагийн хэлтэс, Цүүхийн шинжилгээний алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгийн асуудлыг өөрийн хүрээний мэдэгдэлд тусган холбогдох газарт уламжилан шийдвэрлүүлж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр Хангал суманд Кобан байр, орон нутгийн төсвийн хөрөнгөөр Хангал-Эрдэнэтийн чиглэлийн автозамын хяналтын пост /2,0 сая/, Эрдэнэт-Булганы чиглэлийн автозамын хяналтын пост /12,0сая/, Булган хотын доторх замын тэмдэг тэмдэглэгээнүүд /5,0 сая/, Замын гэрлэн дохио тавихад /6 сая

төгрөгийн/ хөрөнгө оруулалтуудыг хийж гүйцэтгэ лээ. Булган-Эрдэнэтийн чиглэлийн хяналтын постын барилгын гүйцэтгэл 80 хувьтай байна.

Хил хамгаалахад туслах хүчний гишүүдийг үнэмлэхжүүлж, хилчдийн ажиллах нөхцлийг сайжруулах зорилгоор 1,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, аймгийн Тэргүүний хилчдийг шагнаж урамшуулав.


2.4.9. Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, түүний хор хөнөөлийг арилгах талаар

Гарсан гамшиг ослын өнгөрсөн жилтэй харьцуулахад 5 -аар буюу 8 хувь, хохирол 75 сая төгрөг буюу 9 хувиар тус тус өссөн байна.


Ой, хээрийн түймийн тоо 8-аар буюу 40 хувь, хохирол 322.1 саяар буюу 44 дахин, унтраахад гарсан зардал 17 дахин буюу 11,7 сая төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Объектын галын тоо 1-ээр буюу 5 хувь буурч, хохирол 10 сая буюу 5 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Нийт гарсан гамшиг ослын тоо




Галзуу өвчний тохиолдлын тоо, хохирол сүүлийн 5 жилээр



Халдварт боом өвчний тохиолдлын тоо, хохирол сүүлийн 5 жилээр



Усны ослын тохиолдлын тоо, хохирол сүүлийн 5 жилээр



Хүчтэй салхины тохиолдлын хохирол сүүлийн 5 жилээр



2.4.10. Батлан хамгаалахын хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх талаарх бодлого

Батлан хамгаалахын холбогдолтой хууль тогтоомж, төрийн цэргийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлж Зэвсэгт хүчний анги, байгууллагуудыг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах, аймгийн дайчилгааны төлөвлөгөөний хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Дайчилгааны даалгавар бүхий цэргийн анги байгууллагатай хамтран дайчилгааны даалгавраар татан нийлүүлэх бие бүрэлдэхүүн, техникийн тодотголыг бичиг баримтаар тодотгож, материалыг БХЯ, ЗХЖШ-ын холбогдох газар хэлтсүүдэд хүргүүлэв.

Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг цэргийн тоо бүртгэл зохион байгуулах журмын дагуу явуулж, Батлан хамгаалах талаар төр, засгаас явуулж буй бодлого чиглэл, Батлан хамгаалахын холбогдолтой хууль тогтоомжуудыг ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, ЕБС-ийн сурагчдад сурталчлах ажлыг өргөн далайцтай зохион байгууллаа.

БХ-ын Сайддын өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2010 оны 05-р сарын 23-25-ны өдрүүдэд Булган аймгийн хэмжээнд “Батлан хамгаалах бодлого, зорилт ЗХ-ний үйл ажиллагааг сурталчлах өдөрлөг”-ийн арга хэмжээ явагдаж 900 гаруй иргэд эмнэлгийн үзлэг, оношлогоо, эмчилгээнд хамрагдаж, 20 гаруй хагалгаа, мэс ажилбар хийгдэж, урлаг уран сайханы арга хэмжээнүүдийг олноор зохион байгуулж, иргэд хөдөлмөрчдийг өргөнөөр хамрууллаа.

Дэлхийн II дайн дууссаны болон 1945 оны Чөлөөлөх дайны ялалтын 65-н жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлж, Булган аймагт ажиллаж амьдарч буй дайнд оролцсон 28 ахмад дайчинд хүндэтгэл үзүүлэн, 4 хүн төрийн дээд шагнал одон, медалиар шагнагдав.

Аймгийн Засаг дарга, орлогч дарга, ЗДТГ-ын дарга нар БХЯ-аас зохион байгуулсан цэрэг- стратегийн сургалтанд хамрагдаж, сумын удирдлагуудыг аймгийн төвд сургалтанд хамруулав.

БХ-ын Сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээ, дайчилгааны даалгавар бүхий ЗХ-ний анги байгууллага дээр хийсэн тодотголын мөрөөр нэн шаардлагатай байгаа 4 мэргэжлээр дайчилгааны бэлтгэл нөөцийн 1-р зэргийн бэлтгэл үүрэгтэн болон цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж буй иргэдийн 10 хоногийн нэгдсэн сургалтыг Булган аймгийн “Цэргийн үүрэгтэний сургалтын төв”-д зохион байгуулан явууллаа.

2009 оны 1, 2-р ээлжийн цэрэг халах, 2010 оны 1, 2-р ээлжийн цэрэг татах ажлыг зохион байгуулж 260 хүнийг цэргийн жинхэнэ албанд тэнцүүлэн Хилийн болон дотоодын, Ерөнхий зориулалтын цэргийн ангиудад хуваарилан өгч Зэвсэгт Хүчний Жанжин Штабаас өгсөн хяналтын тоог 100 хувь биелүүллээ. Мөн Зэвсэгт хүчний

болон Хилийн цэргийн ангиудад 12 иргэнийг гэрээт цэргийн албанд сонгон шалгаруулалтаар тэнцүүлэн хувиарлаж алба хаалгаж байна.

“Монгол цэргийн өдөр” -ийг Цэргийн штаб, Цэрэг татлагын товчоо тусгай төлөвлөгөөний дагуу тэмдэглэн өнгөрүүлж аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ҮАБХ тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд марш-тактик, тусгай бэлтгэлийн, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд АХА тэмцээн, ”Жаран хар”-ын концерт болон цэргийн сэдэвт дууны тэмцээнийг зохион байгууллаа.

Мөн БХИС, Ахлагчийн коллежи, Хөгжмийн коллежид элсэн орж суралцахыг хүссэн бүрэн дунд боловсролтой хүүхдүүдийн өргөдлийг хүлээн авч холбогдох материалуудыг бүрдүүлэн, бие бялдарын ерөнхий хөгжлийн сорил шалгалт авч, сургуулиудын элсэлтийн босго онооны шалгуурыг хангасан 18 хүүдийг дээрхи сургуулиудад элсүүлэн суралцуулж байна.

Шинээр 18 нас үрч буй ЕБС -ийн болон МӨТ -ийн ахлах ангийн сурагчдыг үнэмлэхжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

3.1. Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт

Аймгийн Засаг даргаас 2010 онд Шадар сайд, Боловсрол соёл шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Зам, тээвэр, барилга, хот байгууллын сайд, Батлан хамгаалахын сайдтай, Хууль зүй дотоод хэргийн сайдтай тус тус үбээгдэхүүн нийлүүлэх санхүүжилтийн гэрээ байгуулан ажиллав.

Д/д	Гэрээний харьяалал	Аймагт хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Гэрээг хэрэгжүүлж зарцуулсан хөрөнгө /сая/	Бүтээг дэхүүний анги	Хэрэгжилтийн хувь
1	Шадар сайд	Онцгой байдлын газар,	619,6	27	95
		Хүүхдийн төлөө хэлтэс,	465,4		
		Мэргэжлийн хяналтын газар	285,5		
		Стандарт хэмжил зүйн хэлтэс	67,3		
2	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд,	Боловсрол соёлын газар	9864,3	2	98
3	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс,	12668,3	5	90
		Нийгмийн даатгалын хэлтэс	10138,1		
4	Эрүүл мэндийн сайд	Эрүүл мэндийн газар,	3768,0	9	92
		Биеийн тамир спортын газар	132,5		
5	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд	Хүнс хөдөө аж ахуй жижиг дунд үйлдвэрийн газар	1152,6	19	92

6	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	Баягаль орчин аялал жуулчлалын газар	174,3	4	97,5
7	Зам, тээвэр, барилга, хот байгууллын сайд	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар	85,05	21	95,2
		Тээвэр авто замын газар	129,0	1	100
8	Батлан хамгаалахын сайдтай	Цэргийн штаб	32,9	4	94,0
9	Хууль зүй дотоод хэргийн сайдтай	Цагдаагийн хэлтэс	648,7	4	90,5

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт

№	Агентлагийн нэр	Оноо	Үнэлгээ	Салбартаа
1	Эрүүл мэндийн газрын дарга	90,8	A	11-р байр
2	Боловсрол соёлын газрын дарга	96,4	A	4-н сард
3	Биеийн тамир спортын газрын дарга	87,7	B	7-р байр
4	Хүүхдийн төлөө хэлтсийн дарга	99,6	A	2-р байр
5	Хүнс хөдө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын дарга	95,6	A	1-р байр
6	Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга	95,8	A	Байр эзлүүлээгүй
7	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга	90,4	A	7-р байр
8	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга	91,5	A	6-р байр
9	Тээвэр авто замын газрын дарга	99,1	A	6-р байр
10	Статистикийн хэлтсийн дарга	91,8	A	8-р байр
11	Татварын хэлтсийн дарга	93,9	A	8-р байр
12	Онцгой байдлын газрын дарга	98,5	A	1-р байр
13	Мэргэжлийн хяналтын газрын дарга	97,7	A	5-р байр
14	Цагдаагийн хэлтсийн дарга	90,9	A	Байр эзлүүлээгүй
15	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга	91,1	A	Байр эзлүүлээгүй
16	Шүүхийн шинжилгээний албаны дарга	96,8	A	Байр эзлүүлээгүй
17	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга	94,5	A	1-р байр
18	Аймгийн ЗДТГ-ын дарга	99,5	A	Байр эзлүүлээгүй

Аймгийн Засаг даргын тамгын газар нөөрийн дүрэмд тусгагдсан чиг үүргийг /ажил үйлчилгээг/ бүтээгдэхүүн нийлүүлэх хэлбэрээр үйл ажиллагааны үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлж гэрээг биел үүлэхэд шаардагдах 491,2 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч ажиллав.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулав.

Удирдлагын академийн ёрийн удирдлагын сургуульд 1 ажилтныг сургаж төгсгөн, 1 ажилтныг элсүүлэн сургаж байна.

Цалингийн сангийн хэмнэлтээс үйл ажиллагаа, мэргэжлийн түвшингийн үнэлгээ, үр дүнгийн гэрээ болон өгсөн үүрэг даалгаварын биелэлт, дүнд үндэслэн ажилтнуудыг урамшуулахад 4,0 сая төгрөг зарцуулав.

Тамгын газрын болон нийтлүүлчлгээний бүх ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт үнэ төлбөргүй хамруулав.

53,2 сая төгрөгийн үнэ бүхий 3 орон сууцыг төрийн албан хаагчдад бүртгэлийн үнээр нь хувьчлав.

Ажилтныг ажилд томилох, өрчлөх, халах, түүнд урамшуулал олгохдоо ТБУСТХ, ТАТХ-ийн холбогдох заалтуудыг баримтлаж ажиллав. 2010 онд тэтгэвэрт гарсан болон өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөхийг хүссэн 3 ажилтныг чөлөөлж, 2 хүнийг ажилд шинээр томилж, 7 ажилтны зэрэг дэвийг шинээр буюу ахиулан олгож, 3 ажилтны зэрэглэлийг ахиулав. Өрийн болон салбар, аймгийн шагналаар шагнагдсан 11 ажилтанд 0,6 сая төгрөгийн урамшуулал, 5 ажилтанд тусламж, 7 ажилтанд тэтгэмж олгож нийт 16,6 сая төгрөг олгов.

ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоол, “Ил тод, нээлттэй байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт” -ийг хангах ажлыг аймгийн Засаг даргын тамгын газар орон нутагтаа өргөн хүрээнд зохион байгуулах зорилт тавин ажиллаж байна.

№	Шалгуур үзүүлэлт	Заалтын тоо	Дүн
1	Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал	7	90,0
2	Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	6	91,6
3	Төсөв санхүүгийн ил тод байдал	7	94,3
4	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	10	89,0
НИЙТ ҮНЭЛГЭЭ		30	91,2

4.1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал

Энэ ажлыг аймгийн Засаг даргын тамгын газар аппарат дээрээ шуурхай эхэлж бусад байгууллагад санаа авахуулах зорилгоор 3 өрлийн самбарын загвар гарган захиалгаар хийлгэж олон нийтэд ил тод хэсэгт байршуулсан.


2010 онд Засгийн газрын 288 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм” -ийг тамгын газрын ажилтнуудад үнэн эхээр нь танилцуулж, сум байгууллагуудад үнэн үүлэн мөрдөн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Сумын Засаг дарга нартай байгуулалтын дүнгийн гэрээн д энэ асуудлыг оруулж хэрэгжилтийг тооцож байна.

Сум, байгууллагуудад ил тод байдлыг хэрхэн зохион байгуулж байгаатай газар дээр нь 4-5 удаа танилцаж зөвлөн туслав.

Аймаг орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, иргэдийн амьдрал, ахуйд шууд үлөөлөхүйц шийдвэр гаргахдаа иргэд, олон нийтийн санал авч тусга х чиглэлийг нутгийн удирдлагын байгууллагууд баримтлан ажиллаж байна. Аймгийн Засаг даргын дэргэд “Олон нийтийн өвлөл байгуулах асуудлыг шийдвэрлэж ”Олон нийтийн зөвлөлийн ажиллах журам”, Олон нийтийн зөвлөлийн сар бүрийн нэгдсэн хэлэлцүүлгийг Иргэний танхимаар зохион байгуулж байх шийдвэрийг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор баталлаа. Засаг дарга, ИТХ-ын нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний шийдвэрийн төсөлд нөлөөллийн шинжилгээ хийж, олон нийтийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж байна.

“Хүүхдэд зориулсан ажилүйлчилгээний нийтлэг журам”, “Шударга иргэний урамшуулал олгох журам”, “Төрийн бус байгууллагын тухай хуулийн төсөл”, “Булган олон нийтийн телевизийн удирдахөвлөлийн бүрэлдэхүүнд нэр дэвшүүлэх”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх аймгийн дэд хөтөлбөр” зэрэг шийдвэрийн төслийн хэлэлцүүлгийг хийлээ. 2010 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгохтой холбогдуулан “Нэг иргэн-нэг санал” хуудсаар өв хөдөөгийн олон тооны иргэдийн санал авч жилийн ажлыг зохион байгуулж, “Аймгийн жөгжлийн цогц бодлого”-ыг боловсруулах ажлыг эрдэмтэн мэргэд, судлаачид, өр нийгмийн ажилтан, нутгийн удирдлагууд болон иргэдийн саналыг үндэслэн зохион байгууллаа. Аймгийн ИТХ, Засаг даргаас орон нутгийн тулгамдсан асуудлаар шийдвэр гаргахын өмнө иргэдийн санал бодлыг сонсох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч, 2011 оныг аймгийн хэмжээнд “Иргэдийн оролцоо ил тод байдлыг өргөтгөх жил” болгон зарлаж, жилийн ажлын нээлтийг хийлээ.



4.2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал

Төрийн албаны олон нийтэд үйлчлэх, мэргэшсэн тогтвортой байх, Монгол улсын иргэн төрийн алба хаах адил тэгш боломжтой байх, ажлын гүйцэтгэл үр дүнг эрхэмлэн дээдлэх зэрэг зарчмыг үргэлж Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтөрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалт, төрийн албаны нөөц бүрдүүлэх, түүнийг хуульд нийцүүлэх зэрэг арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж байна.

Төрийн албаны хүний нөөцийн төлөвлөлт, нөхөн хангалт, боловсон хүчнийг ил тод байдлаар сонгон шалгаруулах журам хэрхэн хэрэгж байг ааг аймгийн хэмжээний 31 төрийн байгууллагад шалгаж, 695 төрийн албан хаагчыг хамрууллаа.

Төрийн албаны тухай хууль, журам зөрчиж, иргэнийг төрийн албанд ажиллуулж байгаа 8 зөрчлийг арилгуулах арга хэмжээ авлаа.

Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалд анх орох иргэдээс баталсан журам, зааврын дагуу шалгалт авах ажлыг нийтэд зарлан зохион байгуулж 24 ажлын байранд 99 үн бүртгүүлж , 98 үн шалгалтад орж 77,5 хувь нь тэнцэж нөөцөд бүртгэгдэж тэдгээрээс 21 төрийн жинхэнэ албанд томилогдов.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт шаардлагатай байсан 1 сул ажлын байрыг нийтэд зарлаж, уг ажлын байранд төрийн жинхэнэ албаны өөр байгууллагад ажиллаж байгаа 1 иргэнийг сонгон ажилд томиллоо.

Сайхан сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Хишиг-Өндөр сумын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, Орхон сумын цэцэрлэгийн эрхлэгчийн ажлын байранд Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаал болон өсвийн байгууллагын ерөнхий менежерийн сонгон шалгаруулалтыг явууллаа.

4.3. Төсөв, санхүүгийн ил тод байдал

2011-2013 оны өтөлбөрт суурилсан дунд хугацааны төсвийн төслийг байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилттой уялдуулан боловсруулж Сангийн ямаар хуулийн хугацаанд хянуулж ажилллаа. 2009 оны орон нутгийн төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн байдалд дүн шинжилгээ хийж, аймгийн ИТХ-ын ээлжит 6 хуралдаанаар хэлэлцүүлэн гүйцэтгэлийг батлуулсан ба орон нутгийн телевизээр шууд дамжуулсан үүний зэрэгцээгээр 2009 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн судалгаа, үнэлт, аймгийн Аудитын байгууллагын төсвийн гүйцэтгэл лийн тайланд хийсэн үнэлт болон 2009 оны эхэнд батлагдсан болон оны дундуур тодотгосон төсвийн төлөвлөгөөг байгууллагын мэдээллийн самбарт байрлуулж, төсвийн зарцуулалтад иргэд олон нийтийн үгээс хяналт тавих боломжийг бүрдүүлсэн, төсвийн талаарх мэдээллийг иргэд, иргэний байгууллага өлөөтэй авах нөхцөл боломжоор хангаж ажиллаж байна.

Орон нутгийн төсвийн 2011 оны төслийг аймгийн ИТХ -ын ээлжит 8-р хуралдаанаар хэлэлцүүлж, төсөв хэлэлцүүлэх явцыг орон нутгийн телевизээр шууд дамжууллаа. Улс орон нутгийн төсвийн орлого зарлагын гүйцэтгэлийн мэдээг иргэд, олон нийтэд “Булган” телевизээр сар бүр хүргэж байна.

4.4. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал

2010 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2612,6 сая төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 703,2 сая төгрөг нийт 3315,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ төлөвлөгдсөн бөгөөд үүнээс шинээр нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 13, харьцуулалтын аргаар 22, шууд гэрээ байгуулах аргаар 25 төсөл арга хэмжээ эг тус тус хэрэглэсэн бөгөөд Нээлттэй тендер шалгаруулалтын журам хэрэглэж байхад Засгийн газрын худалдан авах ажиллагааны вэб сайт www.e-procurement.mn хаяг болон Монголын өдөр тутмын сонинд 1 удаагийн зарыг өгч олон нийтэд хүргэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үнэлгээний хороонд хөндлөнгийн ажиглагчаар орон нутаг дахь иргэний нийгмийн байгууллага өлөөлөл болох 2 хүнийг оролцоулах шийдвэр гаргасан хэдий ч иргэний нийгмийн өлөөлөл тэр бүр идэвхтэй оролцохгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер шалгаруулалтад оролцохыг үссэн иргэн аж ахуйн нэгжүүдийн шалгуур үзүүлэлтийг гаргаж мэдээллийн самбарт байрлуулж ажиллаж байна. Мөн www.e-procurement.mn хаягаар зарласан зарыг дүнг мэдээлж хэвшсэн бөгөөд тендер шалгаруулалттай холбоотой зөрчил гомдлыг шат шатанд нь арилгах мөн холбогдох байгууллагад мэдээлж шийдвэрлүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Тендер шалгаруулалттай холбоотой гомдол, зөрчлийг тухай бүр нь хуульд заасан үндэслэлээр шат шатанд нь шийдвэрлэж, мөн дээд шатны байгууллагуудад шийдвэрлүүлэхээр саналаа өгч хэвшлээ. 2010 онд аймгийн хэмжээнд зохион байгуулсан худалдан авах ажиллагаатай холбоотой 4 өргөдөл ирснийг Сангийн Яамны Худалдан авах ажиллагааны газраар хянуулсан бөгөөд шалгаруулалт хүчин төгөлдөр хэвээр шийдвэрлэгдсэн. Энэ талаархи мэдээллийг тухай бүрт нь самбарт байршуулан олон нийтэд мэдээлж байсан.

ТАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

5.1. Булган аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ

№	Үзүүлэлт	Өмнөх он /2009/	Тайлант он /2010/	Өөрчлөлт	Үнэлгээ	
					Хувь	Оноо
0	1	2	3	4	5	6
1	Эдийн засгийн үзүүлэлт					
1.1	Дотоодын нийт бүтээгдэхүүн (сая.төг)	141673.5	152331.4	10.9	107.5	5.0
1.2	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн (1995 оны зэрэгцүүлэх үнээр, мян.төг)	2446.9	2609.8	162.9	106.6	5.0
1.3	Хэрэглээний үнийн өөрчлөлт / суурь он 2005.12 сар/ (хувь)	162.4	189.0	-26.6	86,0	4.0
1.4	Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт (хувь)	100.4	105.7	5.3	105.2	5.0
1.5	Орон нутгийн төсвийн орлогын өсөлт (хувь)	13.2	13.4	0.2	101.5	5.0
1.6	Төсвийн нийт зардалд өөрийн орлогын эзлэх хувь	120.2	105.5	- 14.7	87.7	4.3
1.7	Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл (хувь)	98.8	100.0	1.2	101.2	5.0
1.8	Орон нутгийн төсвийн урсгал өр, авлага (сая.төг)	14.5	18.1	3.6	96.4	4.8
1.9	Орон нутгийн төсвийн урсгал өр, авлагын өсөлт, бууралт (хувь)	77.5	124.8	47.3	62.0	3.1
1.10	Малын тоо (мян.тол)	2611,6	2293,3	-318,3	87,8	4.4
1.11	Нийт малын тоонд өндөр ашиг шимт үүлдэр, угсаа (мах, сүү, ноос, ноолуурын чиглэлийн)- ны малын эзлэх хувь	6.7	6,2	-0.5	92,5	4.6
1.12	Эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг нэгж (фермер, нөхөрлөл, бүлэг) -ийн тоо	170	185	15	314,5	5.0
1.13	Хураан авсан үр тариа (мян.тн)	48.1	36.1	- 12	75,0	3.7
1.14	Хураан авсан төмс (мян.тн)	8.1	7.6	- 0.5	93.8	4.6
1.15	Хураан авсан хүнсний ногоо (мян.тн)	3,0	3.2	0.2	106.6	5.0
1.16	Хураан авсан малын тэжээл болон бусад таримал (мян.тн)	80.6	97.7	17.1	121.2	5.0
1.17	Тариалангийн талбайд байгуулсан ойн зурвасны хэмжээ (га)	<i>Ойн зурвас хийгдээгүй.</i>				
1.18	Шинээр инженерийн шугам сүлжээнд холбогдсон айл өрхийн тоо	36	50	14	138,8	5.0

1.19	Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газрын талбайн хэмжээ (га)	44.6	67.5	22.8	151.3	5.0
2	Нийгмийн үзүүлэлт					
2.1	Хамран сургалтын хувь: - Сургуулийн өмнөх боловсрол	71.9	85,2	13.3	118,4	5,0
	- Бага боловсрол	95.1	97,6	2,5	102,6	5,0
	- Суурь боловсрол	95.6	98,9	3,3	103,4	5.0
2.2	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хангалтын хувь	96	95,7	-0,3	99,6	4.9
2.3	Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багшийн хангалтын хувь	93.4	95,6	2,2	102,3	5.0
2.4	Нэг компьютерт ногдох хүүхдийн тоо	33	30	-3	110,0	5.0
2.5	Ерөнхий боловсролын түвшин тогтоох шалгалтын онооны дундаж (дунд боловсролын сургуульд)	98,6	98,7	0,1	100,1	5.0
2.6	Ажилгүйдлийн түвшин	11.8	6,0	5,8	196,6	5.0
2.7	Ядуурлын түвшин	21.6	19,2	2,4	112,5	5.0
2.8	Хүн амын дундаж орлого, амьжиргааны баталгаажих доод түвшингийн харьцаа	2.2	2.4	0.2	109,0	5.0
2.6	Шилжих хөдөлгөөний цэвэр коэффициент	- 3,4	- 9,3	- 5,9	36,5	1.8
2.7	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь	66.6	52.9	- 13.7	79.4	3.9
2.8	Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын барагдуулалт (хувь)	68.1	60.4	- 7.7	88.6	4.4
2.9	Эхийн эндэгдлийн түвшин (100000 амьд төрөлтөд)	187.3	-	0	100,0	5.0
2.10	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд)	18.7	20.4	1.7	91,6	4.5
2,11	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд)	21.5	24.5	3	87,7	4.3
2.12	Халдварт өвчний гаралт (10000 хүн амд ногдох)	174.6	132.6	-42	75.9	5,0
2.13	Нэг хүртэлх насны хүүхдийн бүрэн дархлаажуулалтын хамралтын хувь	99.3	99.2	-0.1	99.8	4.9
2.14	Тухайн жилд соёл, урлагийн үйлчилгээг хүртсэн үйлчлүүлэгчдийн тоо	87476	174347	86871	199,3	5.0
2.15	Театр, чуулга, соёлын төвд шинээр болон сэргээн тавьсан бүтээлийн тоо (урлагийн төрөл, хэлбэрээр)	4	4	0	100,0	5.0
2.16	Тухайн жилд соёл, урлагийн байгууллагад зарцуулсан хөрөнгө оруулалт (мян.төг)	155100,0	1157000,0	1001900	745,9	5.0
3	Хөгжлийн үзүүлэлт					
3.1	Агаарын чанарын лаборатори болон хяналтын цэгийн тоо	1	1	0	100,0	5.0
3.2	Шинээр байгуулсан хог хаягдлын төвлөрсөн цэгийн тоо (дахин боловсруулах)	2	3	1	150,0	5,0
3.3	Ногоон байгууламжийн талбайн	2741.7	6352	3610.3	231.6	5,0

	өсөлт (м2)					
3.4	Улсын санд хүлээж авсан ойжуулсан талбайн хэмжээ (га/ жил)	969.4	850	-119,4	87,6	4.3
3.5	Уул уурхайн зориулалтаар олборлолт хийсэн газрын нөхөн сэргээлтийн хувь / техникийн нөхөн сэргээлт/	115.2	90,0	-25,2	78,2	3.9
3.6	Шинээр ашиглалтад орсон хатуу хучилттай замын урт (км)	33.5	111	77.5	331.3	5.0
3.7	Шинээр ашиглалтад орсон орон сууц (айлаар) / 8 айлын 1 орон сууц, 12 айлын амины орон сууц /	83	94	11	113.2	5.0
3.8	Цэвэр, бохир ус ын төвлөрсөн хангамжид хамрагдсан өрхийн нийт өрхийн тоонд эзлэх хувь	10.14	10.14	0	100,0	5.0
3.9	Нийт эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийн жин (хувь)	8.9	9.8	0.90	110.1	5.0
3.10	Жижиг, дунд үйлдвэрийн тоо /шинээр байгуулагдсан/	69	87	18	126,6	5,0
3.11	Жижиг, дунд үйлдвэрт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өсөлтийн хувь	16.9	18.4	1.5	108.8	5.0
3.12	Шинээр бий болсон ажлын байрны тоо	1098	1404	306	127.8	5.0
3.13	Шинээр байгуулсан болон сэргээн засварласан уст цэг, усан сан, худгийн тоо	65	68	3	104.6	5.0
3.14	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл (сая.төг)	3001.2	3911,2	909,9	130,3	5.0
ДУНДАЖ ОНОО					125,6	4,72

5.2. Хэрэглэгчийн үнэлгээ

Иргэдээс авсан судалгааны дүнгээс үзвэл Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн үйл ажиллагаанд судалгаанд хамрагдсан иргэдийн 14 хувь нь маш сайн, 31 хувь нь сайн, 51 хувь нь дунд зэрэг гэж хариулсан бол 2 хувь нь тааруу, 1 хувь нь маш муу болон мэдэхгүй гэж хариулжээ. Аймгийн Засаг дарга болон ЗДТГ-ын үйл ажиллагаанд 48 хувь нь сайн буюу маш сайн, 49 хувь нь дунд зэрэг 3 хувь нь тааруу болон маш муу гэж дүгнэжээ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

/М.ОЮУНБАТ/

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

/Д.БАТЧУЛУУН/

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

(2010 оны үйл ажиллагааны үр дүн)

№	Үзүүлэлт		Үр дүнгийн үнэлгээ	
			хувь	оноо
1	Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ	1.Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт	89,1	4,5
		2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	70,0	3,5
		3.Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт	88,05	4,4
Үнэлгээний дундаж оноо 4.2				
2	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт	97,6	4,9
		2.Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт	95	4,75
		3.Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилт	97,7	4,9
		4.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	81,3	4,1
Үнэлгээний дундаж оноо 4,7				
3	Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	1.Эрхлэх асуудлын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	94,4	4,7
		2.Төсвийн ерөнхийлөн захирагчаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт	94,5	4,7
Үнэлгээний дундаж оноо 4,7				
4	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	1.Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал	90	4,5
		2.Хүний нөөцийн бодлогын ил тод байдал	91,6	4,58
		3.Төсөв, санхүүгийн ил тод байдал	92,9	4,64
		4.Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал	87	4,4
Үнэлгээний дундаж оноо 4,53				
5	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	125,6	4.72
		2.Хэрэглэгчийн үнэлгээ	97	4,85
Үнэлгээний дундаж оноо 4.78				
Ерөнхий үнэлгээ 4.6				

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

М.ОЮУНБАТ